



РИО ТИНТО ТӨСЛҮҮД

**ОЮУ ТОЛГОЙН ГҮНИЙ УУРХАЙН
ТӨСӨЛ**

ХУДАЛДАН АВАЛТЫН ГЭРЭЭ

**ЕРӨНХИЙ НӨХЦӨЛҮҮД
(2018 ОНЫ 8-Р САР)**

АГУУЛГА

	ХУУДАС
БҮЛЭГ А. ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ГОЛ НӨХЦӨЛҮҮД	1
1. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	1
2. ТӨЛӨӨЛӨГЧИД	9
3. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ	10
4. ТОМИЛГОО, ТУСЛАН ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ	11
5. КОМПАНИАС ОЛГОХ МЭДЭЭЛЭЛ	11
6. ГҮЙЦЭТГЭГЧИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮН	11
7. ӨӨРЧЛӨЛТ	11
8. НИЙТЭД МЭДЭЭЛЭХ	14
9. ХУВИЙН НУУЦ, МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ	14
10. НУУЦЛАЛ	14
11. ОЮУНЫ ӨМЧ	15
12. ТӨЛБӨР	16
13. ТАТВАР	19
14. ДААТГАЛ	24
15. ОРОН НУТГИЙН ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИД	25
16. БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ	26
17. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЧАДАМЖГҮЙ БОЛОХ	27
18. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ	29
19. САНХҮҮ БҮРТГЭЛ	30
20. МЭДЭГДЭЛ	30
21. ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ	30
22. УДИРДЛАГА БОЛГОХ ХУУЛЬ	30
23. ГУРАВДАГЧ ТАЛЫН ЭРХ	31
24. ЭРХЭЭС ТАТГАЛЗАХ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ	31
25. НИЙТ ГЭРЭЭ	31
26. ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ	31
27. САНХҮҮЖИЛТИЙН ТОХИРОЛЦОО	31
БҮЛЭГ В. ХУДАЛДАН АВАЛТЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ	33
28. ГҮЙЦЭТГЭХ АЖЛУУД	33
29. БАТАЛГАА	33
30. ҮЗЛЭГ, ШАЛГАЛТ	34
31. ХҮРГЭЛТ	34
32. ЭЗЭМШИЛ, ЭРСДЭЛ	34
33. ГЭРЭЭГ ЦУЦАЛСАН ТОХИОЛДОЛД ГАРАХ ҮР ДАГАВРУУД	35

БҮЛЭГ С. УУРХАЙН ТАЛБАРТАЙ ХОЛБОГДОХ ЗААЛТУУД	37
34. УУРХАЙН ТАЛБАР	37
35. УУРХАЙН ТАЛБАРТ НЭВТРЭХ	37
36. УУРХАЙН ТАЛБАРЫН БУСАД ЗААЛТ	37
37. ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, БАЙГАЛЬ ОРЧИН, ОРОН НУТАГ	37
БҮЛЭГ D. БУСАД ЗААЛТУУД	39
38. ГЭРЭЭ БАЙГУУЛАГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД	39
39. ХҮЧИН ТӨГӨЛДӨР ХЭВЭЭР ҮЛДЭХ	39

БҮЛЭГ А. ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ГОЛ НӨХЦӨЛҮҮД

1. Нэр томъёоны тайлбар

1.1 Энэхүү Гэрээнд зөрчилдөөнтэй утга санаа илрэхгүй бол нэр томъёонууд нь дараах утгыг илэрхийлнэ:

"Төлбөр хуримтлагдах үе" гэж 12.6 дэд заалтад заасан утгыг илэрхийлнэ.

"Салбар компани" гэж гэрээний нэг тал нь хяналтыг хэрэгжүүлж буй эсхүл түүний хяналт дор буй эсхүл нэгдсэн хяналт дор буй аливаа корпораци, компани, нөхөрлөл, хязгаарлагдмал нөхөрлөл, хязгаарлагдмал хариуцлагатай компани, хамтарсан хөрөнгө оруулалттай компани ба аж ахуйн нэгжийн бусад хэлбэрийг ойлгоно. Хянах гэсэн үгийг:

- (a) үйл үгээр хэрэглэх бол тухайн хуулийн этгээдийн удирдлагыг хэрэгжүүлэх, эсхүл удирдлагын бодлого чиглэлд нөлөө үзүүлэх, чиглүүлэхдээ:
 - (i) саналын эрхтэй хувьцааны эсвэл гишүүнчлэлийн ашиг сонирхлын хууль ёсны өмчлөгч болон;
 - (ii) менежер, захирал болон корпорацийн удирдлагыг томилох эрх;
 - (iii) гэрээ;
 - (iv) Үйл ажиллагааны гэрээ, хэлэлцээр;
 - (v) санал өгөх итгэмжлэл;
 - (vi) өөрөөр,
- (b) эсвэл хэрэв аливаа этгээдэд хамаарч хэрэглэгдэж байвал тухайн этгээдийн үйл ажиллагааг хянах бодит, хууль ёсны эрх мэдлийг;
- (c) хэрэв нэр үгээр хэрэглэх бол дээр дурдсан эрх мэдлийн алийг ч хэрэгжүүлэх эрхийг холбогдох этгээдэд олгож буй ашиг сонирхлыг хэлнэ.

"Авлигын Эсрэг Хууль" гэж хээл хахууль болон авлигыг хориглоход зориулагдсан дэлхийн хаана ч байж болох хуулийг хэлнэ: Үүнд:

- (a) *Хээл Хахуулийн Хууль 2010* (НВУ)
- (b) 1977 оны Гадаадын Авлигын Практикийн Хууль (Америкийн Нэгдсэн Улс)
- (c) *Гэмт Хэргийн Хуулийн Сайжруулсан Хувилбар (Гадаадын Төрийн Албан Хаагчдын Хээл Хахууль) 1999 оны Хууль* (Австрали)
- (d) Гадаадын Төрийн Албан Хаагчдын Авлигын Хууль (Канад)
- (e) Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гэмт Хэргийн Хууль (Бүгд Найрамдах Хятад Ард Улс):
- (f) Монгол Улсын Авлигын Эсрэг Хууль, ба
- (g) Монгол Улсын Ашиг Сонирхлын Зөрчлийн Тухай Хууль

"Буцаалтын дүн" гэж Гэрээнд заагдсан болон бусад шаардлагын дагуу Гүйцэтгэгчийн хүлээх үүргийг (улмаар төлөх зардлыг) Компани гүйцэтгэснээс үүссэн зардлыг хэлнэ. Үүнд дараах нөхцөлүүд багтана:

- (a) Гүйцэтгэгчийн ажлын цар хүрээнд багтсан ажил буюу үйлчилгээг Компани гүйцэтгэсэн (Гүйцэтгэгч тал хүсэлт гаргасан эсэхээс үл хамааран).

- (b) Гүйцэтгэгч тал Гэрээний зүйл заалтыг зөрчсөнөөс, эсвэл Гүйцэтгэгчийн аливаа үйлдэл, орхигдуулсан зүйлээс үүдэн Компанид зардал учирсан.
- (c) 29-р зүйлд заасан баталгаат хугацааны хугацаанд Ажлуудад гарсан аливаа дутагдал, доголдол, алдааг залруулахтай холбоотойгоор Компанид учирсан зардал.

"Ажлын өдөр" гэж тус Улсад нийтээр тэмдэглэх баярын өдрүүдээс бусад, бямба, ням гаригуудаас өөр аль нэг өдрийг хэлнэ.

"Иргэний хууль" гэж цаашид нэмэлт өөрчлөлт хийгдэх Монгол улсын Иргэний хуулийг хэлнэ.

"Нэхэмжлэл" гэж ямар ч төрлийн аливаа гомдол, өргөдөл, шүүн таслах ажиллагаа, шаардлага зэргийг хэлнэ (үүнд, Гүйцэтгэгч талаас буюу түүний Бие бүрэлдэхүүнээс, эсвэл аливаа гуравдагч этгээдээс Компанийг бүхэлд нь буюу түүний салбар нэгж, Бие бүрэлдэхүүний эсрэг нэхэмжлэл гаргах хамаарна).

"Эхлэх огноо" гэж Захиалгын маягт дээр заасан утгаар илэрхийлэгдэнэ.

"Харилцаа холбоо" гэж бүх мэдэгдэл, санамж, төлбөрийн нэхэмжлэл, батламж, төлөөлөгч томилох, зөвшөөрөл олгох, тайлан гаргах, мэдэгдэл өгөх, эрх олгох, орлогч томилох, цахим шуудан, Нэхэмжлэл болон бусад харилцаа холбооны хэлбэрүүдийг хэлнэ.

"Компани" гэж Захиалгын маягт дээр заасан утгаар, мөн түүний залгамжлагч, түүнээс томилогдсон этгээдийг хэлнэ.

"Компанийн төлөөлөгч" гэж Захиалгын маягт дээр Компанийн төлөөлөгч гэж заагдсан Этгээдийг буюу 2.2 дэд заалтад заасны дагуу шинээр томилогдсон бусад этгээдийг хэлнэ.

"Компанийн дүрэм" гэж www.riotinto.com/aboutus/policies-standards-and-guidance-5243.aspx хуудсанд тухайн үед тавигдсан буюу Компаниас олж авч болох дүрэм, шаардлага, бодлого, стандартуудыг илэрхийлэх бөгөөд үүнд Рио Тинто Бизнесийн Дадлага Туршлага ба Стандартууд зэрэг баримт бичгүүд хамаарна.

"Компанийн хувийн мэдээлэл" гэж тус Гэрээтэй холбоотойгоор Компаниас Гүйцэтгэгч талд тухай бүрд шилжүүлж өгөх Хувийн мэдээллийг хэлнэ.

"Гүйцэтгэж дуусах огноо" гэж Захиалгын маягт дээр заасан болон энэхүү Ерөнхий нөхцөлүүдээр нэмэлт өөрчлөлт оруулсан гүйцэтгэлийн дуусах өдрийг хэлнэ.

"Нууц мэдээлэл" гэж 10.1 дэд заалтад заасан утгыг илэрхийлнэ.

"Гэрээг цуцалснаас гарах үг дагавар" гэж 31-р зүйлд зааснаар илэрхийлнэ.

"Гэрээ" гэж 1.3 дэд заалтад заасан утгыг илэрхийлнэ.

"Гэрээний Оюуны Өмч" гэж Гэрээний гүйцэтгэлтэй холбоотойгоор үүсгэсэн, нээн илрүүлсэн, бий болсон (одоо болон ирээдүйд) аливаа бүх оюуны өмчийн эрхийг хэлнэ. (Гэрээг гүйцэтгэхдээ Гүйцэтгэгчийн хөгжүүлсэн аливаа зүйлийн оюуны өмчийн эрхийг багтааж ойлгоно)

"Гэрээний үнэ" гэж Захиалгын маягт дээр тусгасан болон цаашид Хуваарь А-д (хэрэв байгаа бол) тусгайлан заасан үнийн дүнг Гэрээний дагуу өөрчлөгдөх байдлаар хэлнэ.

"Гэрээний техникийн нөхцөл шаардлага" гэж Захиалгын маягт дээр өгүүлсэн үзүүлэлтийг аливаа Өөрчлөлтөөр нэмэлт өөрчлөлт орсон байдлаар хэлнэ.

"Гүйцэтгэгч (гүйцэтгэгч, Гүйцэтгэгч)" гэж Захиалгын маягт дээр Гүйцэтгэгч гэсэн нэршлээр илэрхийлэгдсэн Этгээд, түүний залгамжлагч, батлагдан томилогдсон этгээдийг хэлнэ.

"Гүйцэтгэгчийн оюуны өмч" гэж энэхүү гэрээний дагуу нийлүүлсэн аливаа зүйлд хамаарах Гүйцэтгэгчийн оюуны өмчийн эрхийг хэлэх бөгөөд:

- (h) Хэлцэл байгуулагдах үед бий болсон байсан;
- (i) гэрээтэй холбоогүйгээр гэрээ байгуулснаас хойш бий болсон,

байхаас гадна Гэрээний оюуны өмч, эсвэл Рио Тинто-ийн оюуны өмч биш байна.

"Гүйцэтгэгчийн Даатгалын Гэрээ" гэж Захиалгын маяг дээр заасан Гүйцэтгэгчийн даатгалын гэрээг хэлнэ.

"Гүйцэтгэгчийн төлөөлөгч" гэж Захиалгын маягт дээр Этгээд гэж заасныг хэлэх буюу 2.2 дэд заалтын дагуу цаашид шинээр томилогдох мөн тийм Этгээдийг хэлнэ.

"Үнэн зөв төлбөрийн нэхэмжлэл" гэж 12.5 дэд заалтын шаардлагыг хангасан төлбөрийн нэхэмжлэлийг хэлнэ.

"Улс" гэж Монгол Улсыг хэлнэ.

"Гаалийн татвар" гэж Барааг экспортлох, импортлохтой холбоотойгоор эрх бүхий төрийн байгууллагаас ногдуулсан, нэхэмжилсэн, оногдуулсан буюу түүнд төлөх ёстой аливаа татвар, хураамжийг хэлнэ.

"Гэрээний Огноо" гэж Захиалгын маягт дээр заасан утгыг илэрхийлнэ.

"Үүрэг гүйцэтгэх чадамжгүй болсныг мэдэгдэх" гэж гаргасан гэх зөрчлийг заан, гэрээнд оролцогч нөгөө талыг зөрчлөө арилгахыг шаардан бичгээр үйлдсэн мэдэгдэл.

"Чиглэл" гэж Гэрээнд заасны дагуу Компанийн төлөөлөгчөөс Гүйцэтгэгч талд хандан гаргасан аливаа шийдвэр, шаардлага, тодорхойлолт, зааварчилгаа, чиглэл, захиалга, хүсэлтийг хэлэх бөгөөд Чиглэлийн мэдэгдлийн маягт хэлбэрээр, эсвэл тухайн үедээ зохимжтой гэж үзсэн аливаа хэлбэр буюу арга байдлаар гаргана.

"Маргаан" гэж Гэрээтэй холбоотой болон түүнээс үүдэн гарах Талуудын хооронд үүссэн санал бодлын зөрүү, асуудал, маргаан зэргийг хэлнэ.

"Баримтжуулалт" гэж бичиг баримтжуулах, төлөвлөлт, зураг төсөл, дахин хянагдах зураг төслийн мэдээлэл, тооцоолол, мэдээлэл, дата, техникийн үзүүлэлт, үлгэр зураг, тэмдэглэл, дээж, тайлан, байр зүйн зураг, санхүү тооцоо, ашиглалтын гарын авлага, сургалтын материал болон бусад гэрээнд заагдсан материалуудыг хэлнэ (цаасан болон цахим хувилбараар байж болно).

"Монгол улсын дотоодын Гүйцэтгэгч" гэж Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, хувь хүнийг хэлэх бөгөөд Монгол улсын харьяат татвар төлөгч байна.

"Техникийн зураг" гэж Гүйцэтгэгчийг Гэрээг гүйцэтгэхэд шаардлагатай техникийн зургуудыг хэлэх бөгөөд Компанийн төлөөлөгчөөс Гүйцэтгэгч талд гаргаж өгсөн техникийн зургууд хамаарна.

"EFT" гэж цахим банкны шилжүүлгийг хэлнэ.

"Эцсийн хэрэглэгч" гэж энэхүү гэрээний агуулгад ямар нэг сонирхол бүхий Рио Тинто Группийн гишүүнийг хэлэх бөгөөд үүнд тухайн Төсөл болон дурдсан агуулгаас ашиг

хүртэж, ашиглах хамаарна.

"EREI" гэж "валютын ханшийн ил төрөл"-ийг хэлэх ба Хуваарьт энэ нэршлээр тодорхойлогдсон болно.

"Гадаадын Гүйцэтгэгч" гэж Монгол улсад бүртгэлгүй аж ахуйн нэгж, хувь хүнийг хэлнэ.

"Гадаад эх сурвалжтай зүйлүүд" гэж энэхүү Гэрээнд тодорхой заасны дагуу Гүйцэтгэгч тал Монгол улсын Төгрөгөөс бусад валютаар худалдан авсан ажиллах хүч, материал, бусад зүйлүүдийг хэлнэ.

"Санхүүжүүлэгчид" гэж Төсөлд зориулан санхүүжилт гаргаж авч болох Этгээдүүдийг хэлнэ.

"Ерөнхий нөхцөлүүд" гэж энэхүү ерөнхий нөхцөлүүдийг хэлнэ.

"Бараа" гэж Ажлуудыг бүрдүүлэх зорилготой буюу бүрдүүлж буй материал, хангалт, үйлдвэр, тоног төхөөрөмж, нөөц сэлбэг зэрэг бусад эд зүйлсийг хэлнэ.

"Эрх бүхий төрийн байгууллага" гэж аливаа төр засаг (үүнд, улсын, мужийн, дүүргийн, нутаг дэвсгэрийн, бүс нутгийн, орон нутгийн захиргаа хамаарна) буюу төрийн, хагас төрийн, засаг захиргааны, сангийн, шүүхийн байгууллага, хэлтэс, хороо, албад, газрууд, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, зөвлөл, агентлаг буюу хуулийн этгээд, улс өөрөө, аливаа яам, хяналтын газар, албан тушаалтан, төрийн албан хаагч, хянан шалгах буюу зохицуулах эрх бүхий хуулийн этгээдийг хэлнэ.

"Баталгаа гаргагч" гэж Захиалгын маягт дээр заасан утгыг илэрхийлнэ.

"ЭМААБООН" гэж Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчин, Орон нутаг гэдгийг илэрхийлнэ.

"ЭМААБООН-ийн нөхцөл шаардлага" гэж холбогдох хууль дүрэм, түүнчлэн Компанийн ЭМААБООН-ийн дүрмийн дагуу тавигдах нөхцөл шаардлага, тогтолцоо, стандарт, бодлого журам, менежментийн төлөвлөгөө, хөтөлбөр, тусгай зөвшөөрөл зэргийг хэлэх бөгөөд үүнд Хавсралт С-д заасан журмууд хамаарна.

"Шууд бусаар шилжүүлэх татвар" гэж бараа бүтээгдэхүүнийг худалдан авах, борлуулахтай холбоотой ба торгууль, шийтгэврээс бусад төр засгийн эрх бүхий байгууллагаас үнэлж, тогтоож, ногдуулсан НӨА Татвар, бараа болон үйлчилгээний татвар, борлуулалтын татвар, хэрэглээ болон зарцуулалттай холбоотой татвар болон бусад ижил төстэй татварыг хэлнэ.

"Татварын хөнгөлөлт" гэж шууд бусаар шилжүүлэгдсэн аливаа татварыг буцаан олгох, бууруулах, татвартай холбоотой нөхөн төлбөр авах болон хөнгөлөлт эдлэх эрхийг хэлнэ.

"Төлбөрийн чадваргүй болох" гэж Гүйцэтгэгч байгууллага дараах нөхцөл байдлуудад орохыг хэлнэ:

- (a) төлбөрийн чадваргүй болох, дампуурах;
- (b) харгалзагч талд эрх хүлээлгэн өгөх тогтоол гаргах, эсвэл зээлдүүлэгч талуудтай өрийг хэсэгчлэн төлөхөөр тохиролцоо
- (c) төрийн байгууллагын хяналтад шилжих, эсвэл өөрийн үйл ажиллагааг эрх хүлээн авагч, итгэмжлэгч, татан буулгагч, зээлдүүлэгчид болон аль нэг зээлдүүлэгчээс томилсон татан буулгагчийн хяналтад явуулах, түүнчлэн харгалзагч, итгэмжлэгч, татан буулгагч, түр татан буулгагч болон төрийн байгууллагын хяналтад шилжих урьдчилсан алхмууд хийгдэх
- (d) хэрэв компани бол татан буугдах (нэгдэх болон бүтэц зохион байгуулалтыг

өөрчлөх зорилгоор гишүүдийн сайн дурын үндсэн дээр татан буугдаагүй)

- (e) хэрэв түншлэл бол гэрээ байгуулагдах үед уг түншлэлийг бүрдүүлж буй бүх талууд түншлэлээс гарах
- (f) дээр заасан хэсгүүдтэй (а-аас е) адил төстэй үйл явдал өрнөх

"Оюуны өмчийн эрх" гэж нийтийн эрх зүй, хууль тогтоомж, Английн уламжлалын эрх зүйн тогтолцооны дагуу хамгаалагдсан, шинээр зохиосон бүтээлд хадгалагдах бүх зохиогчийн эрх болон ижил төстэй эрхүүд (үүнд бүх патент, патентын өргөдлүүд), худалдааны нууц, ажлын ур чадвар, зураг төсөлтэй холбоотой эрхүүд (бүртгэгдэх ба бүртгэгдэх боломжгүй), бүртгэгдсэн ба бүртгэгдээгүй барааны тэмдэгт, цахилгаан хэлхээний схем түүнд холбогдох эрхийг тус тус хэлнэ.

"Хууль" гэж аливаа хууль, удирдамж болгох хууль, хууль тогтоомж, хууль эрхийн акт, тогтоол, тушаал, дүрэм, эрх бүхий байгууллагын гаргасан тогтоомж, зарлиг, төрийн эрх барих дээд байгууллагын зарлиг, гэрээ, төр засгийн эрх бүхий байгууллагаас гаргасан аливаа тогтоол, мэдэгдэл, мөн энэхүү гэрээнд мөрдлөг болгох, түүнчлэн энэхүү гэрээнд заагдсан талуудын эрх, үүрэг, ажлын гүйцэтгэлд мөрдөгдөх аливаа бичиг баримт.

"Монгол улсын Авлигын Эсрэг хууль" гэж цаашид нэмэлт өөрчлөлт хийгдэх Монгол Улсын Авлигын Эсрэг Хуулийг хэлнэ.

"Монгол улсын Ашиг Сонирхлын Зөрчлийн Тухай Хууль" гэж Төрийн байгууллага дахь нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, зөрчлөөс сэргийлэх тухай цаашид нэмэлт өөрчлөлт хийгдэх хуулийг хэлнэ.

"Монгол улсын Барилгын Хууль" гэж цаашид нэмэлт өөрчлөлт хийгдэх Монгол Улсын Барилгын Тухай Хуулийг хэлнэ.

"Монгол Улсын Галын Аюулгүй Байдлын Тухай Хууль" гэж цаашид нэмэлт өөрчлөлт хийгдэх Монгол Улсын Галын Аюулгүй Байдлын Тухай Хуулийг хэлнэ.

"Монгол улсын Аж Ахуйн Үйл Ажиллагааны Тусгай Зөвшөөрлийн Тухай Хууль" гэж цаашид нэмэлт өөрчлөлт хийгдэх Монгол Улсын Аж Ахуйн Үйл Ажиллагааны Тусгай Зөвшөөрлийн Тухай Хуулийг хэлнэ.

"Монгол Хэлний Тухай Хууль" гэж цаашид нэмэлт өөрчлөлт хийгдэх Монгол Хэлний Тухай Хуулийг Хэлнэ.

"Монгол Улсын ХАБЭА тухай Хууль" гэж цаашид нэмэлт өөрчлөлт хийгдэх Монгол Улсын Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуйн тухай Хуулийг хэлнэ.

"Ажиллах Хүч Гадаадад Гаргах, Гадаадаас Ажиллах Хүч Мэргэжилтэн Авах Тухай" хууль гэж цаашид нэмэлт өөрчлөлт хийгдэх Ажиллах хүч гадаадад гаргах, Гадаадаас Ажиллах хүч Мэргэжилтэн Авах Тухай хуулийг хэлнэ.

"Монгол Улсын Нийгмийн Даатгалын Тухай Хууль" гэж цаашид нэмэлт өөрчлөлт хийгдэх Монгол Улсын Нийгмийн Даатгалын Тухай Хуулийг хэлнэ

"Монгол Улсын Нэмэгдсэн Өртгийн Татварын Тухай Хууль" гэж цаашид нэмэлт өөрчлөлт хийгдэх Монгол Улсын НӨАТ-ын Тухай Хуулийг хэлнэ.

"Хариуцлага" гэж ямар нэгэн зүйл, аливаа нэгэн асуудлаас үүдсэн эвдрэл, нэхэмжлэл, шаардлага, гарз хохирол, хариуцлага, нөхөн төлөгдөх дүн, төлбөр, зардлыг хэлнэ.

"Эвлэрэн зохицох мэдэгдэл" гэж 18.4 дэд заалтад заасан утгаар илэрхийлэгдэнэ.

"Монгол улсын Ажиллах Хүчний Төлбөр" гэж энэхүү гэрээний дагуу (гүйцэтгэгч компани болон туслан гүйцэтгэгч, нийлүүлэгчийн ажиллах хүч) хийгдэх бараа, ажил үүргийг гүйцэтгэхийн тулд Монгол улсад ажиллаж буй гаднын ажилтнуудад "Ажиллах хүч Гадаадад Гаргах, Гадаадаас Ажиллах Хүч Мэргэжилтэн Авах Тухай" хуулийн дагуу олгогдож буй Монгол Улсын хөдөлмөрийн хөлсийг хэлнэ.

"Монгол улсын НӨАТ" гэж Монгол улсын Нэмэгдсэн Өртгийн Албан Татварын Хуулийн 3-р бүлэгт заасны дагуу ажил үйлчилгээ, бараа бүтээгдэхүүнд оногдуулсан татварыг хэлнэ.

"Захиалгын маягт" гэж гэрээгээр гүйцэтгэх Ажил үүрэгтэй холбоотойгоор Компаниас гаргасан худалдан авах захиалгын маягтыг хэлнэ.

"Талууд" гэж энэхүү Гэрээнд оролцогч талуудыг хэлнэ.

"Төлбөр хийгдэх огноо" гэж Захиалгын маягт дээр заасан утгаар илэрхийлэгдэнэ.

"Этгээд" гэж аж ахуй нэгж, корпораци, хамтарсан үйл ажиллагаа, хамтарсан баг болон хувь хүнийг хэлнэ.

"Хувийн мэдээлэл" гэж холбогдох хуульд илүү тодорхой заасан, хувь хүнтэй холбоотой мэдээллийг хэлнэ.

"Бие бүрэлдэхүүн" гэж дараах зүйлсийг хэлнэ:

- (a) Энэхүү гэрээний гүйцэтгэлд шууд ба шууд бусаар оролцогч Гүйцэтгэгч байгууллага, түүний аль нэг ажилтан, Туслан гүйцэтгэгч (туслан гүйцэтгэгчийн ажилтан хамаарна), төлөөлөгч;
- (b) Компанийн хувьд түүний одоо болон өмнө нь ажиллаж байсан ажилтан, агентын төлөөлөгч, төлөөлөгч, Рио Тинто Групп-ын гишүүн, Эцсийн хэрэглэгч (энд дурдсан талуудын ажилтнууд);
- (c) туслан гүйцэтгэгчийн хувьд, түүний аливаа ажилтан, туслан гүйцэтгэгч (туслан гүйцэтгэгчдийн бие бүрэлдэхүүн), төлөөлөгч буюу туслан гүйцэтгэх гэрээнд шууд ба шууд бусаар оролцогч талуудыг хэлнэ.

"Үйлдвэр, тоног төхөөрөмж " гэж Хуваарь F-д заагдсан (байгаа бол) нэрийн зүйлс болон бусад машин тоноглол, үйлдвэр, тоног төхөөрөмж, багаж, барагддаг хэрэглээний зүйлс, түр ажиллах сууц, цахилгаан хэрэгсэл, барилгын шат, хэв хашмал болон Гэрээний гүйцэтгэл ба хэрэгжилтэд шаардагдах бусад төстэй шинж чанарын зүйлсийг хэлнэ (үүнд Бараа хамаарахгүй).

"Боловсруулах" буюу **"Боловсруулалт"** гэж цуглуулах, хадгалах, ашиглах, шилжүүлэх, устгах болон бусад үйлдлийг хэлнэ.

"Төсөл" гэж Захиалгын маягт дээр заасан утгаар илэрхийлэгдэнэ.

"Холбогдох аж ахуйн нэгж" гэж тухайн толгой компани эсвэл толгой компанийн аль нэг салбарыг хэлэх бөгөөд салбар болон толгой компани нь Нэгдсэн Вант Улсын Компанийн Тухай 2006 оны хуулийн 1159 дүгээр зүйлээр оноож өгсөн утгаар тайлбарлагдана.

"Төлөөлөгч" гэж Компанийн Төлөөлөгч болон Гүйцэтгэгчийн төлөөлөгчийг хэлэх бөгөөд тухайн агуулгаас хамааран аль ч талын Төлөөлөгчийг илэрхийлж болно.

"Дахин хянагдах зураг төслийн мэдээлэл" гэж гэрээгээр гүйцэтгэх ажил, хийгдэх тест, барилгын ажил зураг төсөлтэй холбоотой Гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс боловсруулсан бүх техникийн зураг, бичиг баримт, тайлан, төлөвлөгөө, програм, томьёо, тооцоолол,

загвар, нарийвчлал, материалын техникийн үзүүлэлт, гүйцэтгэлийн чанарыг илэрхийлнэ.

“Рио Тинто-ийн Бизнесийн Дадлага туршлага ба Стандартууд” гэдэг нь:

- (a) "Бидний ажлын арга барил", "Ханган Нийлүүлэгчийн Ёс Зүйн Дүрэм" болон "Бизнесийн ёс зүйн стандарт " гэсэн нэр бүхий Рио Тинто Группийн бодлогууд
- (b) "Оюу Толгой ХХК -ны Ёс Зүйн Зарчим" нэр бүхий Компанийн бодлого

"Рио Тинто Групп" гэж Рио Тинто плс болон Рио Тинто Лимитэд нэрээр тус тус бүртгэлтэй компаниудын нэгдэл бөгөөд энэ нь:

- (c) Рио Тинто Плс болон Рио Тинто Лимитэд-ийн аливаа холбогдох салбар нэгж;
- (d) Рио Тинто Плс болон Рио Тинто Лимитэдийн нэгдсэн бүртгэлгүй аливаа хамтын ажиллагаа, мөн Рио Тинто плс, Рио Тинто Лимитэд-ээс үйл ажиллагааных нь 50-с доошгүй хувийг хяналтдаа байлгадаг аж ахуйн нэгж;
- (e) Рио Тинто Плс, Рио Тинто Лимитэд-ийн удирддаг аливаа нэгдсэн бүртгэлгүй хамтын ажиллагаа болон салбар нэгж, эсвэл Рио Тинто плс, Рио Тинто Лимитэд-ийн аливаа салбар нэгж;
- (f) мөн бусад албан ёсоор баталгаажиж хамтран ажиллаж буй хуулийн этгээд.

"Рио Тинто-ийн оюуны өмч" гэж Рио Тинто Группийн аливаа гишүүн болон Компанийн оюуны өмчийн эрхийг хэлэх бөгөөд үүнд дараах эрхүүд хамаарна:

- (a) Хэлцэл байгуулагдах үед бий болсон байсан;
- (b) гэрээтэй холбоогүйгээр гэрээ байгуулснаас хойш бий болсон,

"Рио Тинто Лимитэд" гэж Австрали Улс, Викториа 3000, Мэльбурн, 120 Коллинз Стрийт, 33-р давхарт ажлын байр нь бүртгэлтэй Рио Тинто Лимитэд (ACN 004 458 404)

"Рио Тинто плс" гэж Нэгдсэн Вант Улс, Лондон W2, 6 LG, Истборн Террас-2, д ажлын байр нь бүртгэлтэй Рио Тинто плс (Компаний бүртгэлийн дугаар. 719885)

"SIAC Арбитрын Журам" гэж Сингапур дахь Олон Улсын Арбитрын төвийг хэлнэ

"Уурхайн талбар" гэж Захиалгын маягт дээр заасан газар нутгийн байршлыг хэлнэ.

"Стандарт" гэж энэхүү Гэрээнд тусгасан инженерчлэл, барилгын болон техникийн стандарт, норм, зураг төслийн шалгуур болон техникийн нөхцөлүүдийг хэлэх бөгөөд тэдгээрээс зөрүүтэй буюу өндөр стандарт шаардлага тавигдсан тохиолдолд, Монгол улсын стандарт, ажил үйлчилгээний стандарт, норм, эсвэл Компаниас зөвшөөрөл олгосны үндсэн дээр мөрдөгдөх тэдгээртэй нийцсэн буюу илүү дээд жишигтэй олон улсын стандарт, дүрэм журам байна.

"Туслан гүйцэтгэх гэрээ" гэж Гүйцэтгэгч тал болон аливаа Этгээдийн хооронд байгуулсан гэрээ хэлцэл, тохиролцоо, ойлголцол, түүнээс доод түвшний бичгээр буюу бусад хэлбэрээр зөвшөөрсөн туслан гүйцэтгэх гэрээ байгуулах замаар гүйцэтгэгч тал болон ханган нийлүүлэгчийн нэрийн өмнөөс гэрээнд заагдсан ажил үүргийг бүхэлд нь буюу хэсэгчлэн гүйцэтгэх.

"Туслан гүйцэтгэгч" гэж Туслан гүйцэтгэх гэрээний хүрээнд татагдан оролцсон аливаа Этгээдийг хэлэх бөгөөд тухайн агуулгаас хамаараад Туслан гүйцэтгэгчийн ажилтан үүнд хамаарна.

"Татвар" гэж бүх татварууд, гаалийн татвар, хураамж болон бусад хэлбэрээр ноогдуулсан төлбөр, борлуулалтын татвар, НӨАТ, орлогын татвар, тэмдэгтийн хураамж,

импорт экспортын татвар, онцгой татвар, нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, ажиллах хүчний төлбөр (үүнд монгол улсын ажиллах хүчний төлбөр).

"Татварын нэхэмжлэл" гэж хүчин төгөлдөр хууль дүрмийн дагуу үнэлж, нэхэмжилж, тогтоосон шууд бусаар шилжүүлж төлөгдөх татварын хэмжээг тодорхой заасан нэхэмжлэл, түүнчлэн Компаниас татварын хөнгөлөлт урамшуулал эдлэх боломжийг бүрдүүлэхүйц нэхэмжлэл буюу бусад бичиг баримтыг хэлнэ. (үүнд гүйцэтгэгч болон Компанийн хоорондын төлбөрийн хүсэлт)

"Хугацаа" гэж Ажил үйлчилгээ эхлэх болон дуусах хугацааг илэрхийлэх бөгөөд дуусах хугацаа нь дараах хоёрын аль түрүүлж тохиолдсон нь байна:

- (a) Гэрээний дагуу хүлээсэн бүх үүргээ, үүнд эвдрэл доголдлыг залруулж дуусгах огноо;
- (b) мөн Гэрээ цуцлагдсан огноо.

"Гэрээг цуцлах үнэ" гэж Ажил үүргүүдийн холбогдох гүйцэтгэгдсэн хэсгийн мөнгөн үнэ цэнийг хэлэх бөгөөд түүний хэмжээг Захиалгын маягт болон Хуваарь А-г бодолцсоны үндсэн дээр Компанийн төлөөлөгч тогтооно. Аль ч тохиолдолд Гэрээг цуцлах үнэ нь Гэрээний үнээс давж гарахгүй.

"Худалдааны баталгаа" гэж Туслан гүйцэтгэгчдээс өгсөн ердийн баталгаа болон Компанийн зүгээс Гүйцэтгэгчийг Туслан гүйцэтгэгчээс худалдан авахыг шаардсан бусад худалдааны баталгааг хэлнэ.

"Өөрчлөлт" гэж Ажил үүргүүдийн төлөв байдал эсвэл чанарыг нэмэх, орхигдуулах, ихэсгэх, багасгах, өөрчлөхийг хэлнэ.

"НӨАТ" гэж нэмэгдсэн өртгийн албан татварыг (буюу бусад ижил төстэй татварыг) хэлнэ.

"Ажил үүргүүд" гэж энэхүү Гэрээний дагуу ханган нийлүүлсэн болон үйлдвэрлэсэн Бараа болон бусад бүх гүйцэтгэх зүйлс, тэдгээрээс гарах бүтээгдэхүүнийг (тухайн агуулгаас хамааран) хэлэх бөгөөд Захиалгын маягт дээр шаардсан бүх зүйлс хамаарна.

1.2 Тухайн агуулгад нь өөрөөр заагаагүй бол дараах дүрэм үйлчилнэ:

- (a) Ганц тоо нь олон тоог илэрхийлж болох ба олон тоо нь ганц тоог илэрхийлэх.
- (b) Хүйс гэдэгт бүх хүйсийг хамааруулах.
- (c) Тогтсон аливаа үг хэллэг нь хэлний дүрмийн дагуу өөрөөр бичигдсэн ч үндсэн утгаа санааг илэрхийлэх.
- (d) Үндсэн үг хэллэгүүдийн утга санаа нь "үүнд", "жишээ нь" гэсэн үгээр тодорхойлогдсон жишээнүүдээр хязгаарлагдахгүй.
- (e) Хэрэв өөрөөр заагаагүй бол, аливаа заагдсан өдөр хоногуудыг эхний өдрийг хасаж сүүлийн өдрийг оруулж тоолох ба өдөр гэдэгт хуанлийн өдрийг хэлнэ.
- (f) Иш татсан хууль нь тухайн хуулийн шинэчилсэн найруулга, шинээр баталж, өөрчилсөн хувилбар, дагалдан гарсан нөхцөл шаардлагуудыг хамааруулж ойлгоно.
- (g) Оюуны өмчийн эрхийг ашиглах гэж заасан бол энэ нь ашиглах, хадгалах, хувилах, өөрчлөх, түүнээс санаа авах, хөгжүүлэх, шинэчлэх, нууцлах, бусдад мэдээлэх гэсэн утгаар илэрхийлэгдэнэ.

- (h) Үйлдэл гэдэгт Бичгээр болон бодит үйлдлээр үүрэг хүлээх, мэдэгдэл гаргах, ажил орхигдуулах утгыг хамааруулж ойлгоно
 - (i) Энэхүү гэрээний аль ч заалтыг тухайн гэрээг санал болгосон болон хэсэгчлэн боловсруулсан талын эсрэг тайлбарлахгүй.
 - (j) Энэхүү гэрээнд зааснаар аль нэг тал нь ямар нэг хохирлыг хоёр дахин нөхөн төлөхгүй.
- 1.3 Энэхүү гэрээ нь зөвхөн дараах бичиг баримтаас бүрдэнэ:
- (a) Захиалгын маягт болон Захиалгын маягт дээр хавсаргасан буюу нэгтгэсэн бүх баримт бичгүүд;
 - (b) Ерөнхий нөхцөлүүд; (эдгээр бүх
(хэсгүүдийг хамтад нь "Гэрээ" гэх).
- 1.4 Гүйцэтгэгч нь Захиалгын хуудсыг хүлээж авсны илэрхийлэл болгон Захиалгын маягт дээр гарын үсгээ зурснаар Гэрээ байгуулагдсанд тооцогдоно. Гэхдээ, Компаниас Гүйцэтгэгчид өөрөөр мэдэгдээгүй бол Захиалгын маягт дээр гарын үсэг зуралгүйгээр Захиалгын маягтын аливаа шаардлагыг Гүйцэтгэгч гүйцэтгэсэн нь Компаниас Гүйцэтгэгчид өгсөн Гэрээнд агуулагдсан нөхцөлүүдээр Гэрээг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
- 1.5 Гэрээнд тодорхой зааснаас бусад тохиолдолд Гүйцэтгэгч талд аль ч тохиолдолд (үүнд Компанийн үйлдэл ба эс үйлдэл хамаарна) Гэрээний үнийн дүнг өсгөх, хугацааг сунгах, аливаа төрлийн нөхөн төлбөр авах эрх үүсэхгүй.
- 1.6 Энэхүү гэрээнд илт өөрөөр зөрүүтэй заагаагүй тохиолдолд, гэрээнд оролцогч талууд нь өөрийн зардлаар хүлээсэн үүргээ биелүүлнэ.
- 1.7 Энэхүү гэрээний дагуу:
- (a) Компани эсвэл Компанийн төлөөлөгчөөс өгөх баталгаажуулалт, зөвшөөрлүүд; эсвэл
 - (b) Нэг талаас Компани эсвэл Компанийн төлөөлөгч, нөгөө талаас Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ хэлцэл,
- бүх ашиглагдах материалуудыг дээрх баталгаажуулалт, зөвшөөрөл, гэрээ нь бичгээр үйлдэхийг шаардсан байдлаар тайлбарлана.
- 1.8 Гэрээ байгуулагч аль нэг талаас мэдэгдсэний дагуу эсвэл тухайн гэрээний бичиг баримтад хоёр ба түүнээс дээш тооны хоорондоо зөрүүтэй стандарт шаардлага бүхий бичиг баримт байна гэж үзвэл илүү өндөр түвшний стандарт шаардлагыг мөрдлөг болгоно.
- 1.9 Гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийг дагуу шилжүүлэх мэдээлэл нь бичгээр, Компанийн төлөөлөгчийн шаардлагад нийцүүлсэн байна.
- 2. Төлөөлөгчид**
- 2.1 Талууд Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар өөрийн нэрийн өмнөөс төлөөлж хэрэгжүүлэх бүрэн эрхтэй төлөөлөгчийг томилно.
- 2.2 Нөгөө талдаа бичгээр мэдэгдэл өгөх замаар Төлөөлөгчийг шинээр томилж болно.
- 2.3 Компанийн төлөөлөгчийг Компанийн ашиг сонирхлын төлөө ажиллах эрхтэйгээр

Компани томилно.

3. Гүйцэтгэгчийн хүлээх үүрэг

- 3.1 Гүйцэтгэгч тал нь энэхүү Гэрээнд болон Хуваарь, Хавсралт ба Гэрээний бусад баримт бичигт заасан бүх үүргээ дагаж мөрдөнө.
- 3.2 Энэхүү Гэрээнд Компанийг зарим нэг зүйлсийг хангах үүрэгтэй гэж тодорхой зааснаас бусад тохиолдолд Гүйцэтгэгч тал нь гэрээг зохистойгоор хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх нөөц боломжийг бүрдүүлж ажиллана.
- 3.3 Гүйцэтгэгч тал нь өөрийн бүх ажилтнуудыг дараах дүрэм журмыг мөрдүүлж ажиллуулна:
- (a) бүх хууль дүрэм, төр засгийн эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлага
 - (b) Компанийн дүрэм журам;
 - (c) ЭМААБО-ын шаардлага;
 - (d) Компанийн төлөөлөгчөөс өгсөн Чиглэл
 - (e) бүх зөвшөөрөл, гэрчилгээ
 - (f) бүх холбогдох стандарт
- 3.4 Гүйцэтгэгч тал нь энэхүү гэрээг гүйцэтгэхийн тулд хууль журамд заасан шаардлагыг хангасны үндсэн дээр шаардлагатай бүх ерөнхий зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, бүртгэл буюу эрхийг авч, бүртгэлд хамрагдах үүрэгтэй (энэхүү Гэрээний дагуу Компани хариуцах аливаа ерөнхий зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, бүртгэл, эрх буюу мэдэгдэл зэргийг оролцуулахгүйгээр) бөгөөд хуулийн болон төрийн эрх бүхий байгууллагаас авах шаардлагатай болон авсан бүх зөвшөөрөл, лиценз, бүртгэлийн талаар Компанид мэдээлнэ.
- 3.5 Захиалгын маягтад заасан тохиолдолд Гүйцэтгэгч тал нь Эхэлсэн огнооноос хойш ажлын 20 өдрийн дотор Компанийн хүлээн зөвшөөрөхүйц маягтын дагуу толгой компаниас батлан даалт авч Компанид мэдээлнэ. Гэрээнд заасан бусад заалтыг үл хамааран Компани нь энэхүү 3.5 дэд заалтыг Гүйцэтгэгч тал дагаж мөрдөөгүй тохиолдолд төлбөр хийх үүрэггүй байна.
- 3.6 3.3(c) дэд заалтаар хязгаарлахгүйгээр Гүйцэтгэгч тал, түүний ажилтан нь Ажил үйлчилгээ үзүүлэхдээ дараах зүйлсийг биелүүлнэ:
- (a) “Рио Тинто-ийн Бизнесийн дадлага туршлага, стандартууд”-ыг мөрдөх буюу түүнд нийцүүлэх;
 - (b) Гүйцэтгэгчийн ажлын талбай, баримт бичиг, мэдээ мэдээлэлд (цахим хэлбэрээр хадгалсан баримт бичгийн хамт) нэвтрэх зөвшөөрлийг Компанид олгож, Гүйцэтгэгч Рио Тинто-ийн Бизнесийн дадлага туршлага ба стандартуудыг дагаж мөрдөж буй эсэхийг Компанийн ажилтан баталгаажуулах, хянан шалгах болон аудит хийх үүднээс Гүйцэтгэгчийн ажилчдаас энэхүү Гэрээтэй холбогдуулан ярилцлага авах зөвшөөрөл олгох;
 - (c) “Рио Тинто-ийн Бизнесийн дадлага туршлага ба стандартууд”-ыг хэрхэн мөрдөж байгаа эсхүл эргэлзээ, тээнэгэлзлийн улмаас мөрдөж чадахгүй байгаа тохиолдолд энэ тухайгаа Компанид эсхүл Рио Тинто Группийн “Спийк-АУТ” (Пеггид хандана уу) хөтөлбөрөөр дамжуулан мэдээлэх;
 - (d) “Рио Тинто-ийн Бизнесийн дадлага туршлага ба стандарт”-ыг зөрчсөн нь баттай

бус бол түүний талаарх хяналт шалгалт хийхэд Компанитай нэн даруй бүрэн хэмжээнд хамтарч ажиллах ёстой бөгөөд мөн ажилтнуудаараа мөрдүүлнэ.

4. **Томилгоо, Туслан гүйцэтгэх гэрээ**

- 4.1 Компани нь гүйцэтгэгч талд урьдчилан бичгээр мэдэгдсэний дагуу гэрээг гуравдагч талд шилжүүлэх буюу гүйцэтгүүлэхээр томилох эрхтэй.
- 4.2 Гүйцэтгэгч тал нь Компаниас урьдчилан зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд гэрээний эрх үүргийг бүхэлд нь болон хэсэгчлэн гуравдагч талд эрх шилжүүлэх, томилох эрхгүй. Компани нь ямарваа нэгэн тайлбар өгөхгүйгээр зөвшөөрөл олгохоос татгалзах түүнчлэн өөрийн ашиг сонирхолд нийцнэ гэж үзсэн нөхцөлүүдээр зөвшөөрөл олгох бүрэн эрхтэй.
- 4.3 Гүйцэтгэгч тал нь Компанийн төлөөлөгчөөс урьдчилан зөвшөөрөл аваагүй тохиолдолд Гэрээг бүхэлд нь болон хэсэгчлэн туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхийг хориглоно.
- 4.4 Аль ч Туслан гүйцэтгэх гэрээ (үүнд томилогдсон туслан гүйцэтгэх гэрээ) болон томилгоо (Компани, түүний төлөөлөгчийн зөвшөөрөлтэй эсэхээс үл хамааран) Гүйцэтгэгчийн гэрээнд заасан үүрэг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 4.5 Гүйцэтгэгчийн ажилтнууд нь Гүйцэтгэгчийн гэрээнд заагдсан үүргийг гүйцэтгэх бөгөөд гүйцэтгэгч тал нь өөрийн хүлээсэн үүргийг ажилтнуудад мөрдлөг болгох үүрэгтэй.

5. **Компаниас олгох мэдээлэл**

Компанийн төлөөлөгчөөс Гүйцэтгэгч талд бичгээр мэдэгдсэнээс бусад тохиолдолд, Компанийн нэрийн өмнөөс болон Компанийн төлөөлөгчөөс өгсөн аливаа мэдээллийн үнэн бодит байдлыг хариуцахгүй бөгөөд тухайн мэдээлэлд үндэслэн хэрэгжүүлсэн аливаа үйл ажиллагааг гүйцэтгэгч тал хариуцна.

6. **Гүйцэтгэгчийн бие бүрэлдэхүүн**

- 6.1 Гүйцэтгэгч тал нь:
- (a) Гүйцэтгэгч тал болон түүний Ажилчид Монгол Улсын Нийгмийн Даатгалын тухай Хуулийн дагуу Монгол Улсын Засгийн Газрын Эрх мэдэлтний удирдаж буй нийгмийн даатгалын санд дараах нөхцөлд төлбөр төлөх үүрэгтэйгээ хүлээн зөвшөөрнө.
Гүйцэтгэгчийн ямар нэгэн ажилтан Ажил үүргийн аливаа нэг хэсгийг Монгол Улсын газар нутаг дээр гүйцэтгэх үед;
- (b) Гүйцэтгэгч тал ба түүний ажилчид Монгол Улсын Нийгмийн Даатгалын Тухай Хуулийн дагуу нийгмийн даатгалын санд төлбөр төлөх үүрэг хариуцлагаа биелүүлж байгаа эсэхийг нягтална.
- 6.2 Хэрэв Гүйцэтгэгчийн ямар нэгэн Ажилтан Ажил Үйлчилгээний аливаа нэг хэсгийг гүйцэтгэхээр бол Гүйцэтгэгч тал Монгол Улсын ХАБЭА тухай Хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалаар хангаж, түүнийг хэвээр хадгалах ёстой. Хэрэв Гүйцэтгэгч энэ шаардлагыг биелүүлж чадаагүйгээс болж Компанид ямар нэгэн өр төлбөр үүссэн тохиолдолд Компани уг хариуцлагыг буцаалт хэлбэрээр нөхөн авах эрхтэй.

7. **Өөрчлөлт**

- 7.1 Компанийн Төлөөлөгчийн чиглэлээр хийгдсэн гэрээн дэх өөрчлөлт
- (a) Компанийн төлөөлөгч нь аль ч үед Гүйцэтгэгч талд гэрээнд өөрчлөлт хийх чиглэл өгөх эрхтэй.

- (b) Чиглэл авснаас хойш хоёр хоногт багтаан Гүйцэтгэгч талаас Компанид тухайн өөрчлөлтөөс үүдэн гэрээний гүйцэтгэх огноо, гэрээний үнийн дүнд гарах өөрчлөлтийн талаар өөрсдийн байр суурийг илэрхийлсэн мэдэгдэл өгнө.
- (c) Чиглэл авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан гүйцэтгэгч тал нь Компанийн төлөөлөгчид хандан тухайн өөрчлөлтөөс үүдэн гэрээний гүйцэтгэх огноо, гэрээний үнийн дүнд гарах өөрчлөлтийн талаарх нарийвчилсан мэдэгдлийг өгнө (хэрэв байх бол).
- (d) Компанийн Төлөөлөгч хүсэлт гаргасан нөхцөлд Гүйцэтгэгч тал 7.1(b) ба 7.1(c) дэд заалтуудад тусгасан мэдэгдэлтэй холбоотой нэмэлт мэдээллээр хангах ёстой.
- (e) Хэрэв Гүйцэтгэгч 7.1(b), 7.1(c) буюу 7.1(d) дэд заалтуудын аль нэгийг дагаж мөрдөөгүй бол:
 - (i) Компанийн Төлөөлөгч Гэрээний Үнийн Дүн ба/эсвэл Гэрээний гүйцэтгэх огноонд өөрчлөлт хийгдсэн байвал Гүйцэтгэгчийн талаас гаргасан аливаа Нэхэмжлэл эсвэл хүсэлтийг өөрийн бүрэн эрхийн хүрээнд татгалзаж болно
 - (ii) гүйцэтгэгч талыг тухайн гэрээний үнийн дүн болон хугацааг өөрчлөхгүй байхаар хүлээн зөвшөөрсөнд тооцно.
- (f) Гүйцэтгэгч 7.1(c) эсвэл 7.1(d) (аль нэг нь дараа нь орох) дэд заалтын шаардлагыг биелүүлснээс хойш ажлын 10 өдрийн дотор эсвэл Компанийн Төлөөлөгчийн шаардсан хугацаан дотор Компанийн Төлөөлөгч нь:
 - (i) Өөрчлөлттэй холбоотойгоор Гэрээний үнийн дүн ба гүйцэтгэх огноонд (байгаа бол) гарах өөрчлөлтийг тодорхойлно
 - (ii) "Гэрээний Өөрчлөлт" гэх бичиг баримтыг олгоно
- (g) 7.1(f) дэд заалтын Компанийн Төлөөлөгчийн тодорхойлолттой холбоотой аливаа маргааныг 18-р зүйлд тусгасан маргаан шийдвэрлэх журмаар шийдвэрлэж болно

7.2 Гүйцэтгэгчийн санаачилсан Өөрчлөлт

- (a) Хэрэв Гүйцэтгэгч Компанийн Төлөөлөгчийн удирдамж чиглэл байгаагүйгээс Ажил Үйлчилгээнд Өөрчлөлт орсон гэж үзвэл тухайн нөхцөл байдал бий болсноос хойш хоёр хоногийн дотор Компанийн Төлөөлөгчид болзошгүй Өөрчлөлтийн талаар бичгээр мэдэгдэл гарган өгнө.
- (b) 7.2 (a) дэд заалтад заасны дагуу мэдэгдэл өгснөөс хойш ажлын 10 өдрийн дотор гүйцэтгэгч тал Компанийн төлөөлөгчид мэдэгдэл хүлээлгэн өгнө. Үүнд:
 - (i) Гүйцэтгэгч нь яагаад Өөрчлөлт гарсан тухай шалтгааныг тайлбарлана
 - (ii) тухайн өөрчлөлтөөс үүдэн гэрээний гүйцэтгэх огноо, гэрээний үнийн дүнд (хэрэв байгаа бол) гарах өөрчлөлтийн талаар өөрсдийн байр суурийг илэрхийлнэ.
- (c) Компанийн Төлөөлөгч хүсэлт гаргасан нөхцөлд Гүйцэтгэгч тал 7.2 (b) дэд заалтад тусгасан мэдэгдэлтэй холбоотой нэмэлт мэдээллээр хангах ёстой.
- (d) Хэрэв Гүйцэтгэгч 7.2 (a), 7.2(b) буюу 7.2(c) дэд заалтуудын аль нэгийг дагаж мөрдөөгүй бол:

- (i) Компанийн Төлөөлөгч Гэрээний Үнийн Дүн ба/эсвэл Гэрээний гүйцэтгэх огноонд өөрчлөлт хийгдсэн байвал Гүйцэтгэгчийн талаас гаргасан аливаа Нэхэмжлэл эсвэл хүсэлтийг өөрийн бүрэн эрхийн хүрээнд татгалзаж болно
 - (ii) Гүйцэтгэгч талыг тухайн гэрээний хугацааг сунгахгүйгээр мөн үнийн дүн өөрчлөхгүйгээр Ажил үйлчилгээг гүйцэтгэхийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
- (e) Гүйцэтгэгч 7.2(b) эсвэл 7.2(c) (аль нэг нь дараа нь орж болно) дэд заалтын шаардлагыг биелүүлснээс хойш ажлын 10 өдрийн дотор эсвэл Компанийн Төлөөлөгчийн шаардсан хугацаан дотор Компанийн Төлөөлөгч нь:
- (i) Өөрчлөлт нь Гүйцэтгэгчид хэрэгцээнд зориулагдсан; эсвэл
 - (ii) Өөрчлөлт нь Гүйцэтгэгчийн хариуцаж буй нөхцөл байдлаас шалтгаалж үүссэн.
- (f) Хэрэв Өөрчлөлт нь Гүйцэтгэгчийн хэрэгцээнд зориулагдсан бол, эсвэл Гүйцэтгэгчийн хариуцаж байгаа нөхцөл байдлаас шалтгаалж үүссэн бол Гүйцэтгэгч талд Гэрээний үнийн дүн болон гүйцэтгэх огноог өөрчлөх эрх үүсэхгүй.
- (g) 7.2(f) дэд заалтыг үл хамааран Компанийн төлөөлөгч өөрийн бүрэн эрхийн хүрээнд:
- (i) Гэрээний үнийн дүн ба гүйцэтгэх огноог өөрчлөлт хийхийг зөвшөөрч болно;
 - (ii) "Гэрээний Өөрчлөлт" гэх бичиг баримтыг олгоно
- Эргэлзээнээс зайлсхийхийн тулд тодорхойлоход Компанийн төлөөлөгч 7.2(g) дэд заалтын дагуу өөрийн бүрэн эрхийн хүрээнд Гүйцэтгэгчийн тусын тулд дээрх үйлдлүүдийг зөвшөөрнө.
- (h) Хэрэв Өөрчлөлт нь Гүйцэтгэгчийн хариуцаж аваагүй нөхцөлөөс шалтгаалж үүссэн бол Компанийн төлөөлөгч:
- (i) Өөрчлөлттэй холбоотойгоор Гэрээний үнийн дүн ба гүйцэтгэх огноонд (байгаа бол) гарах өөрчлөлтийг тодорхойлно
 - (ii) "Гэрээний Өөрчлөлт" гэх бичиг баримтыг олгоно
- (i) 7.2(e), 7.2(f) болон 7.2(h) дэд заалтуудад заасан Компанийн Төлөөлөгчийн тодорхойлолттой холбоотой аливаа маргааныг эсвэл 7.2(g) дэд заалтад заасан Компанийн Төлөөлөгчийн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргааныг 18-р зүйлд заасан маргаан шийдвэрлэх журмаар шийдвэрлэнэ.

7.3 Өөрчлөлтийг Үнэлэх

Өөрчлөлтийн үнэ цэнийг (Гэрээний Үнийн Дүн ихсэх эсвэл багасах үед) доор заасан байдлаар тооцоолж бодно.

- (a) Өөрчлөлтөд хамаарах ханшийг Хуваарьт заасан тохиолдолд тэдгээр ханшийг ашиглана.
- (b) Хэрэв Хуваарь Өөрчлөлтөд хамаарах ямар нэгэн ханшийг багтаагаагүй бөгөөд Гэрээний Үнийн дүнг ихэсгэх тохиолдолд Өөрчлөлтийн үнэ цэнэ аль болох бодитой, боломжит хамгийн доод зардал дээр тогтоно.

- (с) Хэрэв Хуваарь Өөрчлөлтөд хамаарах ямар нэгэн ханшийг багтаагаагүй бөгөөд Гэрээний Үнийн дүнг багасгах тохиолдолд Өөрчлөлтийн үнэ цэнэ аль болох бодитой, боломжит зах зээлийн зардал дээр тогтоно.

8. Нийтэд мэдээлэх

Хуулиар болон Гэрээний дагуу зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд Гүйцэтгэгч нь Компаниас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр Гэрээ буюу Төсөлтэй холбоотой олон нийтэд хандсан мэдэгдэл гаргах, мэдээллийг дэлгэх, аливаа төрлийн сурталчилгаа явуулахыг хориглоно.

9. Хувийн нууц, мэдээллийг хамгаалах

9.1 Хуулиар заагдсан үүргээс гадна Гүйцэтгэгч дараах нөхцөлийг хүлээн зөвшөөрнө:

- (а) зөвхөн Гэрээг хэрэгжүүлэх зорилгоор Компанийн Хувийн мэдээллийг боловсруулах;
- (б) Компанийн хувийн мэдээлэл рүү хууль бусаар буюу зөвшөөрөлгүйгээр нэвтрэх, алдах, устгах, буруугаар ашиглах, өөрчлөх, бусдад дэлгэх, гэмтэл учруулах зэрэг үйлдлийн эсрэг зохион байгуулалтын болон техникийн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх; мөн
- (с) Компанийн хувийн мэдээллийг боловсруулахдаа шударга, хууль ёсны, шаардлагатай бүх алхмуудыг хийх, энэ зорилгоор Компанийн хувийн мэдээллийг Компани олж авсан арга замаар Гүйцэтгэгч Компанийн хувийн мэдээллийг Компаниас лавлах эрхтэй.

9.2 Хэрэв аль нэг хувь хүн Компанид хандан Гүйцэтгэгч тал (түүний Бие бүрэлдэхүүн) тухайн хүний Хувийн мэдээллийг зүй бусаар ашигласан талаар гомдол гаргавал Компани цаашид мэдээллийг зүй бусаар ашиглах явдлыг арилгах зорилгоор Гүйцэтгэгчид тухайн гомдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг нэн даруй өгнө.

9.3 Хэрэв хувь хүн Гүйцэтгэгчид хандан Гүйцэтгэгч (түүний Бие бүрэлдэхүүн) Хувийн мэдээллийг нь зүй бусаар ашигласан гэж үзвэл Гүйцэтгэгч дараах арга хэмжээг авах ёстой:

- (а) Компанид уг гомдлыг нэн даруй мэдээлэх; мөн
- (б) тухайн хүн зөвшөөрсөн тохиолдолд тус гомдлыг Хувийн мэдээллийн хамт Компанид шилжүүлэх

10. Нууцлал

10.1 Гүйцэтгэгч ба түүний Бие бүрэлдэхүүн Компаниас урьдчилан тодорхой зөвшөөрөл авалгүйгээр доорх төрлийн мэдээллийг ашиглах (Гэрээний гүйцэтгэлд зайлшгүй шаардлагатайгаас бусад) эсвэл гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно:

- (а) Төсөл буюу Гэрээтэй холбоотой мэдээлэл;
- (б) Компанийн үйл ажиллагаа, түүний Бие бүрэлдэхүүнтэй холбогдох аливаа мэдээлэл;
- (с) Компани, түүний Бие бүрэлдэхүүний ажил хэрэгтэй холбогдох аливаа асуудал;
- (д) Компанийн хувийн мэдээлэл;
- (е) Компанийн цалин хөлсний үнэлгээ, ажилтан, ажилчдын ажлын байрны нөхцөл,

("Нууц мэдээлэл").

- 10.2 10.1(d) болон 10.1(e) дэд заалтуудтай холбоотойгоор 10.1 дэд заалтаар Гүйцэтгэгчийн дараах төрлийн мэдээллийг ашиглах, дэлгэхийг хориглохгүй:
- (a) Компанийг анх мэдээллийг дэлгэх үед тухайн мэдээлэл нь хууль ёсоор Гүйцэтгэгчид бичгээр очсон байсан;
 - (b) Гэрээний нөхцөлийг зөрчихөөргүй, олон нийтэд дэлгэх боломжтой болсон; мэдээлэл
 - (c) тухайн мэдээллийг хууль ёсоор эзэмших эрх бүхий гуравдагч этгээдээс Гүйцэтгэгчид өгөхөд боломжтой мэдээлэл, хэрэв тухайн мэдээллийг Гүйцэтгэгчид гуравдагч этгээдээс хууль ёсоор дэлгэх зөвшөөрлийг олгосон бол.
- 10.3 10.1 дэд заалт нь Гүйцэтгэгчийг дараах тохиолдолд мэдээллийг бусдад дэлгэхийг (ашиглахыг тооцохгүйгээр) хориглохгүй:
- (a) Хуулийн дагуу мэдээллийг дэлгэх шаардлагатай бол;
 - (b) Гүйцэтгэгчээс Компанид тухайн мэдээллийг ил болгохын өмнө мэдэгдэж зөвшөөрөл авсан бол; мөн
 - (c) Гүйцэтгэгч хуулийн дагуу тухайн мэдээллийг нийтэд хязгаарлагдмал байдлаар дэлгэх, түгээх алхам хийх.
- 10.4 Гүйцэтгэгч Гэрээний гүйцэтгэлтэй холбоотой, мөн Компаниас илэрхий зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд Компани болон түүний үл хөдлөх хөрөнгө, үйл ажиллагааны аливаа хэсэг, Бие бүрэлдэхүүний гэр зургийг авахгүй, гар зураг зурахыг хориглоно.
- 10.5 Компанийн хүсэлтээр Гүйцэтгэгч аль болох богино хугацаанд багтаж Нууцлал бүхий мэдээлэл агуулсан цаасан болон цахим бичиг баримтуудыг Компанид өгөх, устгах үүрэгтэй.
- 10.6 Энэхүү 10-р зүйл нь зөвхөн Компанийн эрх ашгийн төлөө байгаад зогсохгүй, мөн энэхүү зүйлд заасан аливаа мэдээллийг сонирхогч Рио Тинто Группийн аливаа гишүүний эрх ашгийн төлөө байна гэдгийг Гүйцэтгэгч хүлээн зөвшөөрнө.

11. Оюуны өмч

11.1 Гүйцэтгэгчийн оюуны өмч

Гүйцэтгэгч тал нь өөрийн оюуны өмчийг энэхүү төсөл буюу Рио Тинто Группийн хэрэгцээнд зориулан тусгай нөхцөлгүй, тараах боломжтой, нэмэлт төлбөргүй, буцалтгүй, бүрэн эзэмших тусгай зөвшөөрөл, дагалдах зөвшөөрөлтэйгөөр Компанид үүгээр олгож байна.

11.2 Гэрээний Оюуны Өмч

Гүйцэтгэгч тал нь гэрээтэй холбоотой бүх оюуны өмчийг Компанид эзэмшүүлэхийг, тухайн оюуны өмч бий болсон даруйд Компанийн өмч болохыг, түүнчлэн Гүйцэтгэгч тал өөрийн болон өөрийн ажилтнуудыг гэрээтэй холбоотой оюуны өмчийн (ажил хийгдэж эхэлсний дараа болон өмнө нь бий болсон) бүх эрх, зохиогчийн эрхийг Компанид аливаа хүндрэл саадгүйгээр шилжүүлэн өгөх үүрэг хүлээсэн болохыг хүлээн зөвшөөрч байна.

11.3 Гүйцэтгэгч талаас өгөх баталгаа

Гүйцэтгэгч тал нь дараах баталгааг өгч байна:

- (a) Гүйцэтгэгч тал нь 11.1 дэд заалтад заасан тусгай зөвшөөрлийг олгох үүрэгтэй;
- (b) Гүйцэтгэгч тал нь Гэрээний бүх оюуны өмчийг Компанид 11.2 дэд заалтад заасны дагуу шилжүүлэх үүрэгтэй.

11.4 Рио Тинто-ийн оюуны өмч

- (a) Гүйцэтгэгч тал нь Компани буюу Рио Тинто Группийн аливаа гишүүн (тухайн нөхцөлөөс хамааран) нь Рио Тинто-ийн бүх оюуны өмчийг эзэмшигч болохыг хүлээн зөвшөөрч байна.
- (b) Гүйцэтгэгч тал нь Рио Тинто-ийн Оюуны өмч, Гэрээний Оюуны Өмчтэй холбоотой аливаа мэдээллийг бүртгүүлэхийг оролдох тухайн оюуны өмчийн хүчинтэй эсэхийг шалгуулах, түүнчлэн бусад этгээдээр дээрх эдгээр үйлдлийг гаргахыг хориглох үүрэгтэй.
- (c) Гэрээний дагуу үүргээ гүйцэтгэхээс бусад ямар нэг зорилгоор Гүйцэтгэгч тал Рио Тинто-ийн оюуны өмч буюу Гэрээний оюуны өмчийг хэрэглэхгүй, бусад Этгээдэд хэрэглэх боломж олгохгүй.

12. Төлбөр

12.1 Гэрээний үнэ

- (a) Гэрээнд заасны дагуу ажил үүргээ хангалттай гүйцэтгэсэн гэж үзсэн тохиолдолд Компани Гүйцэтгэгч талд Гэрээний үнийг төлөх үүрэгтэй.
- (b) Зөвхөн Хуваарь А-д үнийн өсөлт, бууралтын механизмын талаар тусгайлан заасан тохиолдолд Гэрээний үнийг өсгөх эсвэл бууруулна. Үүнээс бусад тохиолдолд Гүйцэтгэгч зардал өсөж, буурсан шалтгаанаар Гэрээний үнийн дүнг өөрчлөх эрхгүй.

12.2 Гүйцэтгэгч тал Гэрээний дагуу өөрт төлөгдөх ёстой төлбөрийн дүнг нэхэмжлэн сар бүр үнэн зөв нэхэмжлэх хүргүүлэх эрхтэй.

12.3 Аль нэг эрх бүхий төрийн байгууллагын хяналтад байдаг арга замаар Гүйцэтгэгч талд ямар нэг төлбөр хийгдэхээр бол уг төлбөрийг хийхэд шаардлагатай зөвшөөрөл, бүртгэлийг Компани хүлээж авахаас нааш тэр нь хийгдэх ёстой төлбөр биш байна. Уг шаардлагатай зөвшөөрөл, бүртгэл гэдэгт Эрх бүхий төрийн байгууллагын, эсвэл хуулиар шаардсан зөвшөөрөл, бүртгэл байж болно. Компанийн хүсэлтээр буюу Эрх бүхий төрийн байгууллагын шаардсанаар Гүйцэтгэгч тал тийм зөвшөөрөл, бүртгэлийг авах зорилгоор бүх баримтжуулалт, дэмжлэг, туслалцааг үзүүлнэ.

12.4 Төлбөрийг цахим банкны шилжүүлгээр хийх.

- (a) Компани болон гүйцэтгэгч талууд өөрөөр харилцан тохиролцоогүй бол Гүйцэтгэгч талд хийгдэх бүх төлбөрийг Гүйцэтгэгч талаас өгсөн банкны дансанд цахим банкны шилжүүлэг ашиглан хийнэ.
- (b) Гүйцэтгэгч тал нь Компанид мэдэгдсэн банкны мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна. Гүйцэтгэгчийн банкны данс өөрчлөгдөх тохиолдолд тухайн өөрчлөлт хүчин төгөлдөр болох огнооноос ажлын 21 өдрийн өмнө Компанийн төлөөлөгчөөс шаардсан маягтаар мэдэгдсэн байна.

12.5 Нэхэмжлэх

- (a) Гүйцэтгэгч талаас нэхэмжлэлийг дараах байдлаар хүлээлгэн өгнө:

Оюу Толгойн Гүний Уурхайн Төсөл
Худалдан авалтын гэрээний Ерөнхий нөхцөл (2018 оны 8-р сар)

- (i) Компанийн заасан компанийн нэрийг дурдах;
 - (ii) Компанийн заасан компанийн хаягийг дурдах;
 - (iii) Компанийн заасан гэрээний гарчиг, дугаарыг дурдах;
 - (iv) Татварын нэхэмжлэлд тавигдсан нөхцөл шаардлагыг дагаж мөрдөх;
 - (v) Компанийн SAP системд үүсгэсэн захиалгын дугаарыг дурдах;
 - (vi) төлөгдөх үнийн дүнгийн үнэн зөв тооцоолол, үүнд шууд бусаар шилжүүлэх татвар болон буцаан олголтын хэмжээ;
 - (vii) нэхэмжлэлийг илгээсэн огноо;
 - (viii) нэхэмжлэлтэй холбоотой бүх бүрдэл хэсгүүдийн мэдээлэл, үүнд холбогдолтой бол огноо, байршил зэрэг;
 - (ix) Компаниас шаардсаны дагуу бусад нэмэлт мэдээллийг хавсаргах
 - (x) Хавсралт F-д заасан нэхэмжлэл гаргах зааварчилгааг дагаж мөрдөх.
- (b) Монгол улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн аливаа ажил үйлчилгээний нэхэмжлэлийг Монгол улсын нутаг дэвсгэрээс гадуур хийгдсэн ажил үйлчилгээнээс тусад нь гаргана.

12.6 Төлбөр хийх хугацаа

- (a) Үнэн зөв хийгдсэн бүх нэхэмжлэлүүд нь хуанлийн сар бүрийн эхний өдрөөс эхлэн хуримтлуулах бөгөөд тухайн хуанлийн сарын сүүлийн өдөр хүртэл хуримтлуулна ("**Төлбөр хуримтлагдах үе**" гэх). Гэрээнд оролцогч талууд гэрээний дагуу төлбөрийг зогсоох, суутгал хийх, хасалт хийх онцгой эрхийн дагуу, Компани нь гүйцэтгэгч талаас шилжүүлсэн нэхэмжлэлийн үнийн дүнтэй санал зөрөлдөөгүй нөхцөлд, Компани нь гүйцэтгэгч талд төлбөр хийгдэхийн өмнөх буюу төлбөр хийгдэх өдөр талуудын хүлээн зөвшөөрсөн үнийн дүнг гүйцэтгэгч талд төлнө.
- (b) Компани нь аливаа маргаантай үнийн дүнгийн төлөлтийг зогсоох эрхтэй.

12.7 Суутган тооцох

Гүйцэтгэгч тал, түүний ажилтнаас Компанид төлөгдөх аливаа өр төлбөрийг Компани гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгах эрхтэй.

12.8 Буцаалт

- (a) Компанийн төлөөлөгч нь аливаа Буцаалтын дүнд хамаарах татварын нэхэмжлэхийг Гүйцэтгэгчид ирүүлнэ.
- (b) Буцаалтын дүн буюу Компанийн Гүйцэтгэгчид 12.7(a) дэд заалтад заасны дагуу гаргасан нэхэмжлэхийг дараах байдлаар тооцоолно:
- (i) хөдөлмөрийн хөлс – Компаниас гарсан бодит зардлыг тооцоолох ба үүн дээр цалингийн зардлын 55 хувийг нэмж тооцох;
 - (ii) материал – ханган нийлүүлэлт, тээвэрлэлтийн бодит нэхэмжлэхийн дагуу тооцоолох, ингэхдээ тухайн материал Уурхайн талбарт хүргэгдсэн байдлыг үндэс болгох;

- (iii) тоног төхөөрөмж – бодит гуравдагч талын түрээсийн зардал, Компанийн тоног төхөөрөмжийн түрээсийн зардал болон бусад нөхцөлүүдийг харгалзан тооцоолох;
- (iv) Компанитай гэрээтэй туслан гүйцэтгэх гэрээ/Туслан гүйцэтгэгчид - Туслан гүйцэтгэгчийг ажиллуулахад Компаниас гарсан бодит зардал;

эдгээр дээр нэмээд,

- (v) 12.8(b)(i)-ээс 12.8(b)(iv) хүртэл дэд заалтуудад заагдсан үнийн дүнгийн нийлбэрийн 25 хувьтай тэнцэх нэмэлт үнийн дүнг Компаниас гарсан үйл ажиллагааны зардал, шууд бус зардал, удирдлагын зардал, захиргааны зардлыг харгалзан Компаниас нэмж тооцно;
 - (vi) Буцаалттай аль нэг байдлаар холбоотой, Компанид ажил үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотойгоор оногдуулсан татвар.
- (c) Компани нь Гүйцэтгэгчид төлөгдөх хуваарьтай буюу төлөгдөх аливаа үнийн дүнгээс 12.8(a) дэд заалтад заасан аливаа татварын нэхэмжлэхийн үнийн дүнг суутгах эрхтэй. 12.8(c) дэд заалтад заасны дагуу ямар нэг суутгал байхгүй нөхцөлд 12.8(a) дэд заалтад заасан татварын нэхэмжлэхийг Гүйцэтгэгчээс ажлын 15 өдөрт багтаан төлнө.
- (d) Хэрэв Гүйцэтгэгч нь өөрийн төлөх үүрэгтэй татварын нэхэмжлэхийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд тухайн нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан Компанийн төлөөлөгчид хандан аливаа зөрүүтэй хэсгүүдийг тодорхойлж бичгээр Компанид мэдэгдэл өгөх, түүнчлэн Компаниас шаардсаны дагуу тухайн холбогдох бичиг баримтыг хүлээлгэн өгч, тухайн маргаантай үнийн дүнг төлөх буюу хүлээн авна. Улмаар Компанийн төлөөлөгч нь тухайн маргаантай үнийн дүн нь бодитой эсэхийг тодорхойлж хариу мэдэгдэл явуулах ба уг мэдэгдлийн дагуу төлбөр ба суутгалын хэмжээг тодорхойлно.
- (e) 12.8 дэд заалтад заасны дагуу Компанийн эдлэх эрх нь Компани өөрийн бусад эрх, үүнд гэрээний дагуу болон бусад эрхүүд, Буцаалтын дүнтэй холбоотой эсвэл бусад байдлаар гарсан Буцаалтын дүнг нөхөн төлүүлэх эрхээсээ татгалзах үндэслэл болохгүй.
- (f) Гүйцэтгэгчийн хэрэгцээнд зориулан захиалагдсан Улаанбаатараас уурхайн талбар хоорондох нислэгийн суудлыг Гүйцэтгэгч ашиглаагүй тохиолдолд уг ашиглагдаагүй суудлын нислэгийн төлбөрийг Буцаалтын дүнгээр тооцно.
- (g) Гүйцэтгэгчийн хэрэгцээнд зориулан захиалагдсан орон байрыг Гүйцэтгэгч ашиглаагүй тохиолдолд уг ашиглагдаагүй орон байрны төлбөрийг Буцаалтын дүнгээр тооцно.
- (h) 12.8(a) дэд заалтыг үл харгалзан Компани нь өөрийн сонголтоор 7-р зүйлийн дагуу Өөрчлөлт оруулах замаар Гэрээний үнийн дүнг бууруулан Буцаалтын дүнг нөхөн авах эрхтэй.

12.9 Суутган тооцох

- (a) Гүйцэтгэгч тал, түүний ажилтан, түүний Туслан гүйцэтгэгчээс Компанид төлөгдөх аливаа өр төлбөрийг, мөн суутгах буюу чөлөөлөхийг хуулиар Компаниас Хуулиар шаардсан аливаа татварыг Компани Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгах эрхтэй.
- (b) Компани нь 12.9(a) дэд заалтад заасан мөнгөн дүнг авч үлдэх буюу суутгаж чадаагүй бол Компани уг дүнгийн төлбөрийг нэхэмжилж болох бөгөөд Гүйцэтгэгч тал уг дүнг нэхэмжлэлийн мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор

Компанид төлөх ёстой.

12.10 Валютын ханшийн тохиргоо

- (a) Ямар нэгэн EREI байх тохиолдолд Талууд EREI-тэй холбоотойгоор гадаад валютын ханшийн хэлбэлзэлд өөрчлөлт гарахад Талуудад санхүүгийн хүндрэл үүсгэхгүй байлгах зарчимд тулгуурлана.
- (b) Талууд Хуваарьт дэлгэрүүлж тавьсан механизмыг ашиглаж 12.10 (a) дэд заалтад заасан зарчимд нөлөөлөл үзүүлнэ.
- (c) 12.10 дэд заалт нь хуулийн дагуу хүчин төгөлдөр хэрэгжих боломжгүй тохиолдолд талууд харилцан зөвшилцөж шийдэлд хүрэх бөгөөд ингэхдээ гэрээ байгуулагч аль ч талд хохирол учруулахгүй байх буюу гадаад валютын ханшийн хэлбэлзлээс үүдэн аль нэг тал нь ашиг олж нөгөө талыг хохироохгүй байх зарчмыг баримтална.

13. ТАТВАР

13.1 Татвар, Шууд бусаар Шилжүүлэх Татвар, болон Суутгалт Татвар – Гадаадын гүйцэтгэгч

- (a) Хэрэв Гүйцэтгэгч нь Гадаадын Гүйцэтгэгч бол энэхүү 13.1 дэд заалт үйлчилнэ.
- (b) Гүйцэтгэгч тал нь татвартай холбоотой хууль дүрэм, тогтоол, эрх бүхий төрийн байгууллагаас тавьсан шаардлагыг дагаж мөрдөхтэй холбоотой бүх зардлыг бие даан хариуцна.

Татвар төлөлт

- (c) 13.1(d) дэд заалтад зааснаас бусад тохиолдолд Гүйцэтгэгч тал нь Ажлыг гүйцэтгэх, бараа бүтээгдэхүүн нийлүүлэхтэй (энэ тохиолдолд Гүйцэтгэгч тал нь холбогдох хуульд заасан татварын хөнгөлөлт, буцаан олголтод хамрагдах талаар хүчин чармайлт гаргаж ажиллах) холбоотойгоор дэлхийн аль ч улс орны төр засгийн эрх бүхий байгууллагын эрх хэмжээний хүрээнд ногдуулсан аль нэг эсвэл бүх төрлийн татварыг (энэхүү 13-р зүйлд заасанчлан шаардлагатай бол суутгах, шилжүүлэх үүрэг мөн орно) төлөх үүрэгтэй.
- (d) 13.1(e) дэд заалтад заасны дагуу Компани нь Монгол улсын Төр Засгийн эрх бүхий байгууллагаас оногдуулсан дараах татварыг төлөх үүрэгтэй:
 - (i) Монгол улсын нутаг дэвсгэрт Бараа нийлүүлэх буюу Ажил гүйцэтгэх бол:
 - (1) Монгол Улсын аливаа НӨАТ;
 - (2) Энд дурдсан бараа үйлчилгээтэй холбоотойгоор тогтоосон шинэчлэн найруулагдсан буюу шинээр батлагдсан Монгол улсын онцгой татвар
 - (ii) Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна Бараа нийлүүлэх буюу ажил гүйцэтгэхтэй холбоотой Монгол Улсын Засгийн Газраас тогтоосон НӨАТ болон Гаалийн Татвар.
- (e) Компани нь 13.1(d) дэд заалтад заасан аливаа татварыг Монгол Улсын Татварын албанд хуулиар зөвшөөрөгдсөн бол шууд хэлбэрээр төлнө (хэрэв шууд хэлбэрээр төлөхийг хуулиар зөвшөөрөөгүй бол гүйцэтгэгч тал тухайн татварыг төлөх бөгөөд Компани тухайн татварын төлбөрийг гүйцэтгэгч талд нөхөн олгоно).

- (f) Гүйцэтгэгчийн төлөх бүх татвар нь гэрээний үнийн дүнд багтсан байх ба гэрээний үнийн дүн дээр нэмж тооцогдохгүй.
- (g) Гүйцэтгэгч нь бараа бүтээгдэхүүнд шаардагдах материал, бүрэлдэхүүн хэсэгт ноогдох гааль, импортын татварыг бууруулах буюу чөлөөлүүлэх зөвшөөрөл олж авах тал дээр Компанитай зөвлөлдөн хамтран ажиллаж өөрийн талаас бүх хүчин чармайлтыг гаргана.
- (h) Гүйцэтгэгч тал нь гадаад гүйцэтгэгч байх тохиолдолд Компани нь:
 - (i) холбогдох хуульд заасны дагуу Компаниас Гүйцэтгэгч талд төлөгдөх төлбөрөөс татварын суутгалыг суутгах;
 - (ii) тэрхүү татварыг Төр засгийн эрх бүхий байгууллагад төлөх;
 - (iii) татвар нөхөн төлсөн баримт эсвэл түүнтэй ижил төстэй баримтыг Гүйцэтгэгч талд нотолгоо болгон хүлээлгэн өгнө.

Эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс, Компанийн төлбөл зохих суутгах татвар нь гэрээний үнийн дүнд багтсан байх ёстой ба гэрээний үнийн дүн дээр нэмэгдэж тооцогдохгүй.

- (i) Хэрэв гүйцэтгэгч тал нь Монгол Улсын газар нутаг дээр Ажил үүрэг гүйцэтгэж байгаа бол, мөн Монгол улс, Гүйцэтгэгчийн харьяалагдах улсын хооронд давхар татварын гэрээтэй бол хуулийн этгээдийн харьяаллыг гэрчлэх баримт бичгийг ирүүлэх шаардлагатай. Хэрэв гүйцэтгэгч нь гадаадын гүйцэтгэгч бөгөөд Монгол улсад төлөх татвараас чөлөөлөгдөх эрхтэй буюу Компани татварын суутгалыг суутгах эрхгүй гэж үзэж байгаа бол, гүйцэтгэгч тал энэ гэрээнд заасны дагуу Компанид эхний болон үүнээс хойш жил тутамд илгээх нэхэмжлэл дээр хуулийн этгээдийн харьяаллыг гэрчлэх бичиг баримтыг эрх бүхий татварын байгууллагаас авч хавсаргана. Хэрэв гүйцэтгэгч хуулийн этгээдийн харьяаллыг гэрчлэх хүчин төгөлдөр бичиг баримт ирүүлээгүй эсвэл ирүүлсэн баримт бичиг нь Монгол Улс, Гүйцэтгэгчийн харьяалагдах улсын хооронд байгуулсан Давхар татварын гэрээний дагуу Монгол улсад төлөх татвараас чөлөөлөгдөх буюу бууруулсан хэмжээгээр төлөх эрхтэй гэдгээ хангалттай нотлон харуулж чадаагүй тохиолдолд:

- (i) Гүйцэтгэгч тал нь тэрхүү суутгал татварыг холбогдох хуульд заасны дагуу тогтоосон хувь хэмжээгээр төлөх шаардлагатай
- (ii) Компани нь холбогдох хуульд заасны дагуу тухайн суутгал татварыг төлөх шаардлагатай нөхцөлд, Компани нь хуульд заасан үүргийнхээ дагуу төлөх буюу суутгах татварыг гүйцэтгэгч талд төлөгдөх төлбөрөөс суутгаж, тэрхүү татварыг төр засгийн эрх бүхий байгууллагад нөхөн төлөх ба уг суутгал хийгдсэний нотолгоо болгож, холбогдох баримт түүнтэй ижил нотолгоог гүйцэтгэгчид хүргүүлнэ,

мөн, эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс, Компанийн төлбөл зохих суутгах татвар нь гэрээний үнийн дүнд багтсан байх ёстой ба гэрээний үнийн дүн дээр нэмэгдэж тооцогдохгүй.

- (j) Хэрэв гүйцэтгэгч нь Монгол улсын нутаг дэвсгэрт явуулж буй үйл ажиллагаанаасаа хамааран Монгол Улсад тогтмол үйл ажиллагаа явуулах шаардлагатай нөхцөл үүсвэл Компанид нэн даруй мэдэгдэх ба монгол улсын аж ахуй нэгжийн орлогын албан татвар төлөгчөөр бүртгүүлж, татварын буцаан олголтын бичиг баримтыг бие даан бүрдүүлэх буюу Монгол улсын нутаг дэвсгэрт

үйл ажиллагаа явуулж олсон орлогын татварыг төлнө. Энэ тохиолдолд Компани тогтмол үйл ажиллагаа явуулах хугацаанд суутгал татварыг суутгахгүй бөгөөд гүйцэтгэгч тал татвар, татварын суутгалтай холбоотой аливаа торгууль, шийтгэлээс үүдэн Компанийн амссан хохирлыг барагдуулах үүрэгтэй.

- (k) Гүйцэтгэгч тал нь дараах хэсгүүдэд татварын нэхэмжлэлийг тусад нь гаргана:
- (i) Бараа бүтээгдэхүүн;
 - (ii) Монгол улсын нутаг дэвсгэрт Ажил гүйцэтгэх бол:
 - (iii) Монгол улсын нутаг дэвсгэрээс гадна Ажил гүйцэтгэх бол:
 - (iv) Нөхөн төлөгдөх зардалд тооцох зардлууд буюу гуравдагч талд төлбөр хийхийг нотолсон төлбөрийн баримтын хуулга, нөхөн төлөгдөх төлбөрийн задаргаа. 13.1(l)(iv) дэд заалтад заасан нөхөн төлөгдөх зардлын тооцооллыг хүргүүлэхдээ гүйцэтгэгч тал нь хариуцсан Этгээдийн цагийн бүртгэлийн хуудас, ажилласан огноо, цаг, ажлын тайлбар, гүйцэтгэгчтэй ажлыг хийсэн газрын байршлыг хамтад нь дурдана. Гуравдагч талын төлбөрийн баримтын хуулга нь гэрээнд заагдсан нөхөн төлөгдөх төлбөр нь үндэслэлтэй болохыг хангалттай нотолж чадахуйц байна.
- (l) Гүйцэтгэгч нь Компанийн бичгээр ирүүлсэн хүсэлтэд үндэслэн:
- (i) аливаа төрийн эрх бүхий байгууллагад татварын мэдээлэл гаргаж өгөхөд шаардлагатай Аж ахуйн нэгжийн бүртгэл, НӨАТ-ын бүртгэлийн гэрчилгээ зэрэг аливаа буюу бүх мэдээлэл, маягтууд;
 - (ii) Компанийн шаардлагад нийцсэн маягт, агуулга бүхий худалдааны Татварын нэхэмжлэхүүд;
 - (iii) НӨАТ-ын хуульд заасан шаардлагыг хангасан НӨАТ-ын падааныг тус тус Компанид бэлдэж өгнө.
- (m) Компаниас гүйцэтгэгчид хийх төлбөрт татварын суутгал хийгдээгүй боловч, хуулийн дагуу уг суутгалыг хийх шаардлагатай эсвэл гүйцэтгэгчид өгсөн төлбөрт уг суутгалыг тооцсон боловч тооцсон хэмжээнээс өндөр хэмжээгээр суутгал хийхээр хуульд заасан бол гүйцэтгэгч нь албан ёсны баримт(эсвэл түүний баталгаажуулсан хуулбар), эсвэл тухайн дүнг суутгах эсвэл өндөр хэмжээгээр суутгах ёстойг нотолсон бусад баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор суутгах ёстой буюу өндөр хэмжээгээр суутгал хийх дүнг Компанид нөхөн олгох буюу төлнө.
- (n) Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч, дамжуулан нийлүүлэгч татвар, татварын хуультай холбоотой үүргээ биелүүлээгүйгээс үүссэн аливаа болон бүх хариуцлага, нэхэмжлэх, төлбөрийн шаардлага, гарз, хохирол, зардлыг (өмгөөлөгчийн зохих хөлс, хүү, торгууль, хураамж зэргийг оролцуулан) хүлээх, төлөх үүргээс Компанийг чөлөөлж, хохиролгүй болгоно.
- 13.2 Татвар, Шууд бусаар Шилжүүлэх Татвар, Суутгах татвар – Монгол улсын Дотоодын Гүйцэтгэгч
- (a) Хэрэв гүйцэтгэгч нь монгол улсын дотоодын аж ахуй нэгж бол энэхүү 13.2 дэд заалт үйлчилнэ.
 - (b) Гүйцэтгэгч тал нь татвартай холбоотой хууль дүрэм, тогтоол, төр засгийн байгууллагаас тавьсан шаардлагыг дагаж мөрдөхтэй холбоотой бүх зардлыг бие даан хариуцна. Монгол улсын хуулиар шаардсан тохиолдолд Компани нь

гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс татварыг суутган төлнө. (Компанийн суутгах уг татвар нь Гэрээний үнийн дүнд багтсан байх ба Гэрээний үнийн дүн дээр нэмэгдэж тооцогдохгүй)

Татвар төлөлт

- (c) Гүйцэтгэгч тал нь энэхүү гэрээнд заасны дагуу Бараа материал буюу Ажил үүргээр хангахтай холбоотойгоор (энэ тохиолдолд гүйцэтгэгч тал нь холбогдох хуульд заасан татварын хөнгөлөлт, буцаан олголт хамрагдах талаар хүчин чармайлт гаргаж ажиллана) дэлхийн аль ч улс орны төр засгийн эрх бүхий байгууллагын эрх хэмжээнд хүрээнд ногдуулсан аль нэг эсвэл бүх төрлийн татварыг төлөх үүрэгтэй. (энэхүү 13.2(c) дэд заалтад заасанчлан шаардлагатай бол суутгах, шилжүүлэх зэрэг үүрэг мөн орно).
- (d) Гүйцэтгэгчийн төлөх бүх татвар нь гэрээний үнийн дүнд багтсан байх ба гэрээний үнийн дүн дээр нэмж тооцогдохгүй. Эргэлзээнээс зайлсхийхийн тулд тодорхойлоход Гэрээний Үнийн дүнд Компаниас төлөх Монгол улсын НӨАТ ороогүй.
- (e) Гүйцэтгэгч нь бараа бүтээгдэхүүнд шаардагдах материал, бүрэлдэхүүн хэсэгт ноогдох гааль, импортын татварыг бууруулах буюу чөлөөлүүлэх зөвшөөрөл олж авах тал дээр Компанитай зөвлөлдөн хамтран ажиллаж өөрийн талаас бүх хүчин чармайлтыг гаргана.
- (f) Гүйцэтгэгч нь Компанийн бичгээр ирүүлсэн хүсэлтэд үндэслэн:
 - (i) аливаа төрийн эрх бүхий байгууллагад татварын мэдээлэл гаргаж өгөхөд шаардлагатай Аж ахуйн нэгжийн бүртгэл, НӨАТ-ын бүртгэлийн гэрчилгээ зэрэг аливаа буюу бүх мэдээлэл, маягтууд;
 - (ii) Компанийн шаардлагад нийцсэн маягт, агуулга бүхий худалдааны Татварын нэхэмжлэхүүд;
 - (iii) НӨАТ-ын хуульд заасан шаардлагыг хангасан НӨАТ-ын падааныг тус тус Компанид бэлдэж өгнө.
- (g) Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч, дамжуулан нийлүүлэгч татвар, татварын хуультай холбоотой үүргээ биелүүлээгүйгээс үүссэн аливаа болон бүх хариуцлага, нэхэмжлэх, төлбөрийн шаардлага, гарз, хохирол, зардлыг (өмгөөлөгчийн зохих хөлс, хүү, торгууль, хураамж зэргийг оролцуулан) хүлээх, төлөх үүргээс Компанийг чөлөөлж, хохиролгүй болгоно.
- (h) Гүйцэтгэгч нь Монгол улсад бүртгэлтэй аж ахуй нэгж болохын хувьд хэрэв гэрээнд Компани гүйцэтгэгч талыг орон байр, хоол хүнс, нислэгээр хангана гэж заасан бол:
 - (i) тухайн орон байр, хүнс, нислэгийг зохицуулахад гарсан зардалтай холбоотой НӨАТ-ын болон худалдааны татварын нэхэмжлэлийг гүйцэтгэгч талд хүргүүлнэ
 - (ii) Гүйцэтгэгч энэхүү Гэрээ болон 12.8(f) эсвэл 12.8(g) дэд заалтад тусгасан орон байр, хоол хүнс, нислэгийн зардлаас давж гараагүй тохиолдолд Гүйцэтгэгч тал нь Компаниас ирүүлсэн нэхэмжлэлтэй ижил үнийн дүн бүхий худалдааны татварын нэхэмжлэлийг хүргүүлж болно

13.3 Гаалийн татвар

FCA (Incoterms 2010) нөхцөлөөр импортолсон Бараа материалтай холбоотой заалтууд

(a) FCA (Incoterms 2010) нөхцөлөөр ханган нийлүүлсэн бараа материалд дараах заалтууд үйлчилнэ. Үүнд:

(i) Компани Монгол улсын төрийн эрх бүхий байгууллагаас ногдуулсан эсвэл төлбөл зохих бүх Гаалийн татварыг хариуцна.

Гүйцэтгэгч нь:

(ii) Монгол улсын төрийн эрх бүхий байгууллагаас ногдуулсан эсвэл төлбөл зохих бүх Гаалийн татварыг (11.3(a)(i) дэд заалтад зааснаас бусад) болон олон улсын тээвэрлэлттэй холбоотой бусад төлбөрийг хариуцах ба тэдгээрээс чөлөөлөгдөх;

Гүйцэтгэгч нь

(iii) дараах зорилгоор ашиглахад шаардлагатай бүх баримт бичиг, мэдээллээр Компанийг хангах үүрэгтэй. Үүнд:

(A) бараа материалыг Монгол улс руу импортлох гаалийн мэдүүлэг бүрдүүлэх;

(B) Компанийг гаалийн татварын хөнгөлөлт, хоёр улсын хооронд байгуулсан чөлөөт худалдааны хэлэлцээр (буюу түүнтэй дүйцэх)-ийн хүсэлт гаргахтай холбоотой бүх хуульд нийцсэн бүх мэдээлэл бичиг баримтыг Компанийн шаардлагад нийцсэн маягт агуулгын дагуу бэлтгэж өгөх;

(C) хоёр улсын хооронд байгуулсан чөлөөт худалдааны хэлэлцээр (буюу түүнтэй дүйцэх)-ийн дагуу боломжтой тохиолдол бүрд Бараа материалыг Монгол улс руу Гаалийн татваргүйгээр импортлох боломжийг Компанид олгох.

(iv) Хэрэв Гүйцэтгэгч Гаалийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд амжилттай хамрагдсан тохиолдолд түүний ашиг тусыг Компанид шилжүүлэх үүрэг хүлээнэ.

Гэрээний дагуу гүйцэтгэх ажилтай холбоотойгоор DDP (Incoterms 2010) нөхцөлөөр эсвэл аливаа бусад нөхцөлөөр Гүйцэтгэгчийн нэр дээр импортлосон Бараа материалтай холбоотой заалтууд

(b) Гэрээний дагуу гүйцэтгэх ажилтай холбоотойгоор DDP (Incoterms 2010) нөхцөлөөр эсвэл аливаа бусад нөхцөлөөр Гүйцэтгэгчийн нэр дээр ханган нийлүүлсэн бараа материалд дараах заалтууд үйлчилнэ. Үүнд:

(i) Гүйцэтгэгч нь дараах үүрэгтэй:

(A) Үйлдвэрлэгч улс орноос бараа материалыг экспортлох бүх гаалийн бүрдүүлэлтийг гүйцэтгэн, Монгол улсад импортлон оруулж ирэх;

(B) Бараа материалын экспорт болон импорттой холбоотой бүхий л шаардлага (бүх зөвшөөрөл, лиценз гэх мэт)-ыг хангах;

(C) Бараа материалын экспорт болон импорттой холбоотой бүхий л Гаалийн татвар, бусад шимтгэл хураамж, төлбөр эсвэл зардлыг төлөх.

(ii) Боломжтой тохиолдол бүрд Гүйцэтгэгч нь хоёр улсын хооронд байгуулсан

- чөлөөт худалдааны хэлэлцээр (буюу түүнтэй дүйцэх)-ийн дагуу Бараа материалыг Монгол улс руу Гаалийн татваргүйгээр импортлох.
- (iii) Хэрэв Гүйцэтгэгч Гаалийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд амжилттай хамрагдсан тохиолдолд түүний ашиг тусыг Компанид шилжүүлэх үүрэг хүлээнэ.
 - (iv) Гүйцэтгэгч нь
 - (A) Компанид хүргүүлсэн;
 - (B) Гэрээний дагуу гүйцэтгэх Ажилтай холбоотой Гүйцэтгэгчийн нэр дээр импортолсон

бүх Бараа материалд Монгол улсын Гаалийн бүрдүүлэлтийн баримт бичгийн хуулбарыг дагалдуулах үүрэгтэй.

- (v) Компанийн төлөөлөгчөөс хүсэлт гаргасан тохиолдолд Гүйцэтгэгч Бараа материалын импорттой холбоотой бүхий л мэдээлэл, баримт бичгийг ханган өгөх үүрэг хүлээнэ.

14. Даатгал

14.1 Гүйцэтгэгчийн даатгалууд

Гүйцэтгэгч тал нь дараах байдлаар Гүйцэтгэгчийн даатгалын гэрээнүүдийг авч хүчинтэй хадгална:

- (a) энэхүү Гэрээний гүйцэтгэлээс үүдэлтэй эсвэл үүсэж болох эсвэл үүссэн эрсдэл эсвэл тохиолдолтой холбоотойгоор энэхүү Гэрээний хүчинтэй хугацааны туршид болон Компаниас шаардлагатай гэж үзсэн аливаа нэмэлт хугацаагаар;
- (b) Гэрээний хүчинтэй хугацааны туршид холбогдох хуулиар заагдсан аливаа бусад даатгалын гэрээг авч хүчинтэй хадгална;
- (c) хэрэв ажилтнууд нь өндөр эрсдэлтэй ажил гүйцэтгэдэг бол Монгол улсын ХАБЭА тухай хуульд заасны дагуу 36 сарын дундаж цалингаас доошгүй үнийн дүнгээр өөрийн ажилчдаа амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах.

14.2 Нэмэлт шаардлагууд

- (a) Гүйцэтгэгчийн даатгалын гэрээ нь хуулиар хориглоогүй бол дараах нөхцөлийг баталгаажуулсан байна:
 - (i) Компани болон тэдгээрийн ажилтнуудын эрх, ашиг сонирхлыг хамгаалсан байх;
 - (ii) даатгуулагч нэг тал нөгөө талын эсрэг гомдол гаргах эрхтэй тухай заалт оруулах, үүнд даатгалд хамрагдсан талууд бие даасан хуулийн этгээд болохыг дурдах
 - (iii) суброгаци зарчмаар олгогдсон Компани, түүний ажилтны эсрэг гэрээнд заагдсан буюу заагдаагүй бүх эрхээс татгалзах
 - (iv) даатгуулагч аль нэг этгээд даатгалын нөхцөлийг зөрчсөн тохиолдолд даатгуулагч нөгөө этгээдийн даатгалд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх

14.2 (a)(i) болон 14.2 (a)(ii) дэд заалтуудад зааснаас бусдаар аливаа мэргэжлийн хариуцлагын даатгал болон ажилчдын нөхөн олговор, хариуцлагын даатгалд энэ нь үйлчлэхгүй.

- (b) Гүйцэтгэгчийн даатгалын гэрээнд урьдчилан төлөгдөх даатгал, даатгуулагчийн өөрийн хүлээх хариуцлага, урьдчилан үнийн дүнг төлөх тухай заасан тохиолдолд Гүйцэтгэгчийн хариуцан төлөх аливаа гарз хохиролтой холбоотой үнийн дүн, даатгуулагчийн өөрийн хүлээх хариуцлагын талаар Компанид мэдэгдэнэ. Компани нь гэрээний нөхцөл шаардлагын дагуу зохимжтой гэж үзсэн хэмжээгээр Гүйцэтгэгчийн өөртөө даатгах хариуцлага, даатгуулагчийн өөрийн хүлээх хариуцлагын үнийн дүнг бууруулах шаардлага тавих эрхтэй.
- (c) Гүйцэтгэгч тал нь Эй Эм Бест- компанийн А-с доошгүй зэрэглэлтэй, нэр хүнд бүхий даатгалын компаниар даатгуулах буюу давхар даатгуулсан байх үүрэгтэй бөгөөд тухайн улс оронд ажил гүйцэтгэхэд тавигдах шаардлагын дагуу(Компаниас хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд), эрсдэлийн менежментийн тэргүүний туршлагыг даатгалын гэрээнд тусгах нөхцөлтэйгээр Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан даатгалын компанид даатгуулна.
- (d) 14-р зүйлд заасан аливаа заалт нь гүйцэтгэгч талыг гэрээнд заасны дагуу хүлээсэн үүрэг, үүнд Компанийн хохирлыг барагдуулах үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- (e) Хуваарьт заасан хугацаанд даатгалын гэрээ шинэчлэгдэх эсвэл өөрчлөгдөх бүрд, ба/эсвэл Компанийн төлөөлөгчөөс хүсэлт гаргасан тохиолдолд гүйцэтгэгч талаас Компанийн төлөөлөгчид холбогдох даатгалын гэрчилгээ, гэрээнд заасны дагуу туслан гүйцэтгэгч, гүйцэтгэгч талууд даатгалд хамрагдсаныг нотлох баримтыг хүргүүлнэ.
- (f) Гүйцэтгэгч тал 14-р зүйлд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Компани өөрийн шийдвэрээр, холбогдох даатгалд хамруулах ба уг зардлыг Буцаалт хэлбэрээр нөхөн төлүүлнэ.
- (g) Гүйцэтгэгч тал нь гүйцэтгэгчийн даатгалын гэрээг Компанид хохирол учруулах байдлаар шинэчлэхгүй байх, мөн гэрээг хүчин төгөлдөр, зөв шударгаар байгуулах үүрэгтэй.
- (h) Гэрээнд заагдсан даатгалын гэрээний дагуу гүйцэтгэгч талд хүртэх үр өгөөжийг туслан гүйцэтгэгч тал мөн адил хүртэх нөхцөлийг гүйцэтгэгч тал бүрдүүлж өгөх үүрэг хүлээнэ.

15. **Орон нутгийн ханган нийлүүлэгчид**

15.1 Гүйцэтгэгч тал нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, дүрэмтэй нийцэхгүй гэж үзэх, түүнчлэн тухайн ажил үүргийг гүйцэтгэх боломжгүйг нотлон харуулснаас бусад тохиолдолд (үнийн дүн, чанар, хүрэх үр дүн, үйлчилгээ) орон нутгаас хамтран ажиллах боломжтой ажилтан, ханган нийлүүлэгчид, үйлдвэрлэгчдийг гэрээний ажилд оролцуулах үүрэгтэй бөгөөд орон нутгаас авч ажиллуулах боломжгүй тохиолдолд тухайн улс орноос авч ашиглах үүрэгтэй. Үүнд дараах хамаарна:

- (a) орон нутгийн ажилтан, ханган нийлүүлэгчид, үйлдвэрлэгчдэд тендерт оролцох шударга, нээлттэй боломж олгох
- (b) дараах ажилтан, ханган нийлүүлэгчид, үйлдвэрлэгчдэд түлхүү боломж олгоно:
 - (i) тухайн орон нутгийн;
 - (ii) тухайн улс орны;
 - (iii) орон нутгийн болон тухайн улсын оролцоо бүхий тендер, үнийн санал;

(iv) бусад бүх.

- 15.2 Компанийн төлөөлөгчөөс зөвшөөрөл олгосноос бусад тохиолдолд, гүйцэтгэгч тал аливаа туслан гүйцэтгэх гэрээнд 15.1 дэд заалтад заагдсан хүлээсэн үүргээ биелүүлэх бөгөөд Компанийн төлөөлөгчид тухайн нөхцөлийг хангасан туслан гүйцэтгэгчийн талаарх мэдээллийг өгнө.
- 15.3 Гүйцэтгэгч тал нь ажил эхэлснээс хойш 1 сарын хугацаанд багтаан болон сар тутамд, эсвэл Компанийн төлөөлөгчийн заасан хугацаанд багтаан Компанийн шаардсан маягтын дагуу Гүйцэтгэгчийн 15-р зүйлд заасан үүрэг хариуцлага, түүний хэрэгжилтийн талаарх тайланг өгнө.

16. Бизнесийн ёс зүй

16.1 Холбогдох шаардлага, бодлогуудын биелэлт

- (a) Гүйцэтгэгч энэхүү Гэрээн дэх өөрийн үүрэг хариуцлагатай холбоотой бүх Хууль, шаардлагуудыг мөрдөнө.
- (b) Талуудын зорилго нь олон нийтийн буюу арилжааны хээл хахуулийн шинжтэй аливаа төлбөр, шилжүүлэг хийхгүй байх, хүлээж авах буюу зөвшөөрөх, сүрдүүлэн мөнгө авах, бохир мөнгө буюу бусад хууль бус, зохисгүй үйлдэл гаргахгүй байх юм.
- (c) Гүйцэтгэгч Гэрээнд нарийвчлан авч үзсэн аливаа зүй бус давуу тал, ашиг хонжооноос сэргийлэх үүднээс гуравдагч этгээдээр шууд ба шууд бусаар дамжуулан хэн нэгэн (үүнд төрийн албан тушаалтан, хувь хүн, аж ахуйн нэгж орно) рүү төлбөр төлөх, шилжүүлэг хийхийг санал болгох, төлбөр төлөх, тэгэхээр амлах, төлбөр, шилжүүлэг хийх зөвшөөрөл өгөхгүй байхыг тохирон батална.
- (d) Гүйцэтгэгч Гэрээтэй холбоотойгоор хэн нэгнээс (үүнд төрийн албан тушаалтан, хувь хүн, аж ахуйн нэгж орно) аливаа зүй бус давуу тал, ашиг хонжоо бий болгоход нөлөөлөх хээл хахууль буюу бусад зүй бус ашиг хонжоо (хөнгөлөлтийн төлбөрийг оруулан шинж тэмдэг, үнийн дүн хамаарахгүйгээр) шууд ба шууд бусаар санал болгох, төлөх, амлах, зөвшөөрөл өгөх, хүсэх, хүлээн авах ёсгүй.
- (e) Гүйцэтгэгч Авлигын эсрэг хуулийг зөрчихгүй бөгөөд аливаа хууль бус явдалд холбогдохгүй. Гүйцэтгэгч хэн нэгэн Гүйцэтгэгчид Компани буюу Рио Тинто Групптэй хамаатай аливаа хээл хахуулийн зорилгоор хандвал Компанид нэн даруй мэдэгдэнэ.
- (f) Гүйцэтгэгч Рио Тинто-ийн Бизнесийн дадлага туршлага, стандартыг өөрийн болгон нутагшуулна.
- (g) Гүйцэтгэгч энэхүү 16.1 дэд заалтыг зөрчвөл гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу Компанид мэдэгдэн Компани буюу Рио Тинто Групптэй гарсан зөрчлийг тогтоон хамтран ажиллах ёстой. Хэрэв Компани буюу Рио Тинто Групп Гүйцэтгэгчийг Компани буюу Рио Тинто Группт холбогдох хуульд заасны дагуу эд материалын хохирол учруулах эрсдэлтэй зөрчил гаргасан гэж үзвэл тухайн зөрчлийг залруулах боломжгүй зөрчил гэж үзэн тус тохиолдолд энэхүү Гэрээн дэх эрхийг хэрэгжүүлж болох боловч энэхүү Гэрээнд заасан хүлээх хугацаа буюу залруулах хугацааг харгалзахгүй.
- (h) Гүйцэтгэгч нь энэхүү 16.1 дэд заалтад заасантай адил гэрээний заалтуудыг мөрдөн биелүүлэхийг хүлээн зөвшөөрөхийг Ажилтнуудаасаа шаардах ёстой.

- (i) Гүйцэтгэгч Ажилтнаа энэхүү 16.1 дэд заалтад орсонтой үндсэндээ адил гэрээгээр хүлээсэн үүргүүдээ биелүүлэхийг шаардана. Гүйцэтгэгч Компани буюу Рио Тинтогийн хүсэлтээр 16.1 дэд заалтын дагуу үүрэг хариуцлагаа биелүүлэхээ бичгээр батлан Компани буюу Рио Тинто Группийн хүссэн мэдээллээр хангах буюу Гэрээний хэрэгжилтийг хангах үүднээс Гүйцэтгэгчийн бүртгэл, мэдээлэл рүү нэвтрэх (мөн хуулбарыг авах) эрхийг өгнө.

16.2 Аудитын эрх

- (a) Гүйцэтгэгч Компани буюу Рио Тинто Групп, түүний аудитор, бусад зөвлөхүүдийг Гүйцэтгэгчийн аливаа үл хөдлөх хөрөнгө, Ажилтнууд болон холбогдох бүртгэлийг авахыг зөвшөөрнө. Үүнд:
 - (i) Гүйцэтгэгч нь Гэрээг гүйцэтгэж эхлэх огнооноос өмнө энэхүү Гэрээг байгуулахтай холбоотойгоор Авлигын эсрэг хууль эсвэл Рио Тинто-ийн Бизнесийн ёс зүйн дүрэм, стандартыг зөрчил үүсгэж болох аливаа үйлдэл гаргаагүй гэдэг баталгааг гаргаж өгөх;
 - (ii) Гүйцэтгэгч үүрэг хариуцлагаа Гэрээний дагуу биелүүлж буйг баталгаажуулахад шаардагдах холбогдох бүртгэлийг авах;
 - (iii) Аливаа Авлигын эсрэг хуулийг зөрчсөн байх сэжигтэй эсвэл эргэлзээтэй зөрчлийг шалгах; эсвэл
 - (iv) Төрийн эрх бүхий байгууллагын хууль хэрэгжүүлэх хүсэлтийг гүйцэтгэнэ.
- (b) Гүйцэтгэгч Компани буюу Рио Тинто Групптэй (түүний аудитор, бусад зөвлөхүүд) аливаа аудиттай холбоотой бүх ажилд хамтран ажиллан, туслалцаа үзүүлнэ. Компани, Рио Тинто Групп, түүний гуравдагч талын төлөөлөгчид Гүйцэтгэгчийн үл хөдлөх хөрөнгөд нэвтрэн аливаа бүртгэл, мэдээллийн хуулбарыг авах, Гүйцэтгэгчийг Гэрээний үүрэг хариуцлагаа биелүүлж буйг шалгахад Ажилтантай нь уулзах эрхтэй. Гүйцэтгэгч энэхүү Гэрээний хугацаанд болон Гэрээг цуцалснаас буюу Эцсийн байдлаар дуусгавар болсны дараа 3 жилийн хугацаанд аудит хийгдэхэд шаардлагатай бүх туслалцааг үзүүлнэ.

16.3 Маргаан

- (a) Гүйцэтгэгч нь:
 - (i) Компани буюу Рио Тинто Групптэй маргаанд хүргэх, хүргэж болзошгүй аливаа шууд ба шууд бус ашиг сонирхол байхгүйг; мөн
 - (ii) Компани буюу Рио Тинто Групптэй маргаанд хүргэх, хүргэж болзошгүй аливаа шууд ба шууд бус ашиг сонирхлын нөхцөл байдал үүсгэхээс зайлсхийнэ гэдгээ батална.
- (b) Гүйцэтгэгч энэхүү Гэрээний аль ч хугацаанд 16.3 дэд заалтад заасан баталгааг давтах боломжгүй болоход хүргэсэн нөхцөл байдал, мэдлэг мэдэгдэхүүний өөрчлөлт гарвал Компанид даруй мэдэгдэнэ.
- (c) Хэрэв Гүйцэтгэгч 16.3 дэд заалтад заасан баталгааг давтах боломжгүй бол Гэрээг зөрчсөн үндэслэл болох ба Компани гэрээг цуцлах эрхтэй болж Гэрээнд заасан хугацааг үл харгалзана. Гүйцэтгэгч аливаа нөхөн төлбөр, нөхөн олговор нэхэмжлэх эрхгүй болно.

17. Гэрээг цуцлах, үйл ажиллагаа явуулах чадамжгүй болох

17.1 Гүйцэтгэгч тал үйл ажиллагаа явуулах чадамжгүй болох

- (a) Хэрэв гүйцэтгэгч гэрээг зөрчвөл:
 - (i) Компанийн төлөөлөгч, Компани нь гүйцэтгэгч талд ажил үйлчилгээ гүйцэтгэх чадамжгүй болсон тухай мэдэгдлийг хүргүүлэх ба Гүйцэтгэгч талыг зөрчлийг арилгуулахыг шаардана
 - (ii) Компани, түүний төлөөлөгч нь зөрчлийг арилгах боломжгүй гэж үзвэл Компани гүйцэтгэгчид мэдэгдэл өгч, улмаар гэрээг цуцлах эрхтэй
- (b) Дараах алхмыг хэрэгжүүлээгүй бол:
 - (i) үйл ажиллагаа явуулах чадамжгүй болсон тухай мэдэгдэл ирүүлснээс ажлын 10 өдөрт багтаан зөрчлийг арилгах;
 - (ii) мэдэгдэл авснаас ажлын 10 өдөрт багтаан зохих хугацаанд багтаан үйл ажиллагаанд бий болсон зөрчлийг арилгах тухай баталгааг хүргүүлэх (Компани, Компанийн төлөөлөгчийн шаардлагад нийцүүлэн)
 - (iii) нотолгоог хүргүүлсний дараа зохих хугацаанд багтаан зөрчлийг арилгах, үүний дараа Компани Гүйцэтгэгчид мэдэгдэл өгч дараах алхмыг хийнэ:
 - (iv) Гэрээг хэсэгчлэн болон бүхэлд нь нэн даруй цуцлах; эсвэл
 - (v) зөрчлийг арилгах хүртэл гэрээний дагуу төлбөрийг зогсооно.

17.2 Төлбөрийн чадваргүй болох

- (a) Хэрэв төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд Компани энэхүү гэрээнд эрх, үүрэг хүлээсэн гүйцэтгэгч тал болон бусад этгээдэд мэдэгдэл өгч гэрээг цуцлах эрхтэй.
- (b) Гүйцэтгэгч нь төлбөрийн чадамжгүй болсон тохиолдолд Компанид нэн даруй мэдэгдэл хүргүүлэх үүрэгтэй.

17.3 Гэрээг болзолгүйгээр цуцлах

Гэрээнд заагдсан Компанийн эрхүүдээс гадна Компани ямар ч үед өөрийн шийдвэрээр энэхүү гэрээг бие даан болон өөр Гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх зорилгоор гэрээг хэсэгчлэн болон бүхэлд нь цуцлах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд ажлын 3 хоногт багтаан гүйцэтгэгч талд бичгээр мэдэгдэл өгч гэрээг цуцална. Хэрэв Компани гэрээг цуцлахаар завдсан хэдий ч уг гэрээний бусад зүйл заалтын дагуу Компанид гэрээг цуцлах эрх олгогдоогүй бол энэхүү 17.3 дэд заалтад заасны дагуу гэрээг цуцалсан гэж үзэх бөгөөд үүний дараа гэрээ цуцалсны дараах зүйл заалтуудыг мөрдлөг болгоно.

17.4 Компани үйл ажиллагаа явуулах чадамжгүй болох

- (a) Компани нь гэрээнд заасны дагуу дараах нөхцөлд төлбөрөө хийж чадаагүй тохиолдолд:
 - (i) Компанид гэрээтэй холбоотойгоор болон бусад байдлаар гэрээний төлбөрийг хойшлуулах, суутгах, зогсоох эрх үүсээгүй.
 - (ii) Компаниас төлбөр хийх үүрэгтэй холбоотой аливаа маргаан үүсээгүй

Дээрх тохиолдолд гүйцэтгэгчээс Компанид хандан үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон тухай мэдэгдэл хүргүүлэх бөгөөд энэхүү мэдэгдэлд 17.4 дэд заалтад заасны дагуу уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 30 өдөрт багтаан Компаниас төлбөрөө хийгээгүй тохиолдолд гэрээг цуцлах тухай дурдана.

- (b) Хэрэв Компани үйл ажиллагаа явуулах чадамжгүй тухай мэдэгдэл авснаас ажлын 30 өдрийн дотор хүндэтгэх шалтгаангүйгээр төлбөрөө хийгээгүй бол гүйцэтгэгчээс Компанид дараах мэдэгдлийг өгөх эрхтэй:
 - (i) гэрээг нэн даруй цуцлах тухай
 - (ii) гэрээнд заасан бусад заалтуудыг үл харгалзан гэрээний дагуу хийгдэх ажлыг зогсоох

17.5 Гэрээ цуцалсныг хүчин төгөлдөр болгох

- (a) гэрээнд оролцогч аль нэг тал 17 эсвэл 18-р зүйлд заасны дагуу гэрээг цуцлах мэдэгдэл өгч, тухайн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс, эсвэл мэдэгдэлд заасан хожмын өдрөөс гэрээг цуцлагдсан гэж үзнэ.
- (b) 17-р зүйлд заасны дагуу Компаниас авсан аливаа арга хэмжээ нь гэрээнд оролцогч талуудын гэрээг цуцлах хүртэл хүлээсэн үүрэг, хариуцлага, эрх мэдэл, эрх, хохирол нөхөн төлүүлэх эрхийг хязгаарлахгүй. (бүгд хүчин төгөлдөр үйлчилнэ).

17.6 Дангаараа гэрээг цуцлах эрх

Талуудын гэрээг цуцлах эрх нь гэрээнд тодорхой заасан зүйл заалтуудаар хязгаарлагдах бөгөөд өөр бусад эрхүүд үүнд хамаарахгүй.

18. Маргаан шийдвэрлэх

18.1 Аль ч үед аливаа маргаан гарсан тохиолдолд талууд нь аливаа шүүн таслах ажиллагаанаас урьтаж тухайн маргааныг харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг зорино.

18.2 Тухайн бий болсон маргаанаас бусад гэрээгээр хүлээсэн үүргээ талууд үргэлжлүүлэн гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

18.3 Төлөөлөгчид маргааныг шийдвэрлэх алхам хийх

Хэрэв төлөөлөгчид тухайн маргааныг шийдвэрлэх талаар 18.1 дэд заалтад заасны дагуу зөвлөлдөж шийдвэрлэж чадаагүй тохиолдолд аль нэг талаас нөгөө талд тэрхүү маргааныг энэхүү 18.3 дэд заалтад заасны дагуу шийдвэрлэх шаардлага тавина. Тухайн маргааныг талуудын гүйцэтгэх удирдлагад хүргэж шилжүүлнэ.

18.4 Эвлэрэн зохицох

18.3 дэд заалтад заасан зөвлөлдөх үйл явцын дараа Компани ба гүйцэтгэгч тал маргааныг шийдвэрлээгүй бол зөвлөлдөж дууссаны дараа гэрээний аль нэг талаас нөгөө талд маргааныг эвлэрлийн журмаар шийдэх зорилгоор мэдэгдэл хүргүүлнэ ("эвлэрэн зохицох мэдэгдэл"). 18.3 дэд заалтад заасан мэдэгдлийг хүргэснээс хойш ажлын 20 өдрийн хугацаагаар (буюу Талуудын бичгээр хүлээн зөвшөөрсөн өөр цаг хугацааны дотор) Талууд Эвлэрэн зохицох мэдэгдлийг бие биедээ гаргах эрхгүй.

18.5 Арбитраар шийдвэрлэх

Хэрэв 18.4 дэд заалтын дагуу Эвлэрэн зохицох мэдэгдэл хүргүүлснээс ажлын 50 өдрийн

дотор (эсвэл талуудаас бичгээр тогтоосон хугацаанд) маргааныг шийдвэрлэж чадаагүй бол тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж буй Сингапурын олон улсын арбитраын дүрмээр эцэслэн шийдвэрлэгдэх бөгөөд тэрхүү дүрмийг энэхүү гэрээний 18.5 дэд заалтад багтсан гэж үзнэ. Арбитраын үйл ажиллагаа нь гурван арбитраын ажилтнаас бүрдэх бөгөөд талууд тус бүр нэг арбитраын ажилтныг томилж, хурлын даргалагчаар хоёр талын томилсон ажилтан сонгож томилно. Арбитраын хурал Сингапур улсад явагдах бөгөөд арбитраын үйл ажиллагааны хэл нь Англи хэл байна.

19. Санхүү бүртгэл

19.1 Гүйцэтгэгч тал нь санхүү бүртгэлийн хүлээн зөвшөөрөгдсөн, оновчтой зарчмыг баримтлан гэрээний явцад гарсан зарлагатай холбоотой санхүү бүртгэлийн баримт, бичгүүд, данс тооцоог үзэж шалгах боломжтой хэлбэрээр доод тал нь 12 сарын хугацаанд хадгална.

19.2 Гэрээний хугацаа дууссанаас хойш 12 сар хүртэлх хугацаанд Компани, түүний томилсон ажилтан нь 19.1 дэд заалтад заагдсан санхүү бүртгэлийн бичиг баримтыг шалгах, магадлах эрхтэй бөгөөд гүйцэтгэгч тал нь ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

20. Мэдэгдэл

20.1 Гэрээний явцад харилцан явуулах мэдээлэл нь Англи хэлээр, бичгээр хийгдэнэ.

20.2 Харилцан явуулах мэдээлэл нь:

(a) аливаа имэйл, шуудан холбоонд гэрээний хуваарьт заасан дугаар, хаягийг ашиглана

(b) Компанийн төлөөлөгчид биеэр хүргэж өгөх

20.3 Шуудангаар, биеэр, эсвэл цахим шууданд хавсаргаж явуулсан мэдээллийг дараах нөхцөлд хүлээн авсан гэж үзнэ:

(a) тухайн ажлын өдрийн өглөөний 5 цагт шилжүүлэх буюу хүлээн авсан (хүргэх хаягт)

(b) бусад тохиолдолд дараагийн ажлын өдөр

20.4 Талууд Захиалгын маягтад заагдсан имэйл хаяг, ажлын байршил өөрчлөгдсөн бол тухай бүрд бичгээр мэдэгдэнэ.

21. Хохирлыг нөхөн төлөх

21.1 Гүйцэтгэгч тал нь дараах үйлдлээс шалтгаалан Компани болон түүний ажилтанд учирсан хохирлыг нөхөн төлнө:

(a) гүйцэтгэгч, түүний ажилтан нь гэрээний дагуу Гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийг зөрчих (үүнд баталгаат хугацаа)

(b) гүйцэтгэгч, гүйцэтгэгчийн ажилтны үйлдлээс болж өмч хөрөнгө сүйдэх, эвдрэх, алдагдах, хүн гэмтэж бэртэх, амь насаа алдах

21.2 Гэрээнд заагдсан хохирол барагдуулах заалт нь Гүйцэтгэгчийн хүлээсэн ажил үүргээс тусдаа, салангид, тогтмол хүчинтэй байх үүрэг хариуцлага юм.

21.3 Гүйцэтгэгч нь гэрээтэй холбоотой аливаа асуудлаар Компанийн ажилтны эсрэг нэхэмжлэл гаргахыг хориглоно.

22. Удирдлага болгох хууль

- 22.1 Энэхүү гэрээ нь Английн холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулагдана.
- 22.2 Талууд нь:
- (a) 22.1 дэд заалтад заагдсан удирдлага болгох хуулийг талууд харилцан өөрсдийн хүсэл зоригоор сонгосон болохыг хүлээн зөвшөөрч байна
 - (b) талууд 22.1 дэд заалтад заасан удирдлага болгох хууль нь зохимжтой эсэхийг нягтлах үүднээс энэхүү гэрээнд оролцохын өмнө бие даасан хууль эрх зүйн болон бусад чиглэлийн зөвлөгөө авсан болно
- 22.3 Энэхүү гэрээг Англи, Монгол хэл дээр боловсруулсан бөгөөд гэрээний утга агуулгатай холбоотой ямар нэг зөрчил гарч ирэх тохиолдолд Англи хэл дээрх гэрээг мөрдлөг болгоно

23. Гуравдагч талын эрх

- 23.1 23.2 дэд заалтад заасны дагуу гэрээний аливаа заалтыг энэ гэрээнд оролцоогүй аливаа этгээд хэрэгжүүлэх, ашиг олохыг хориглох ба Гэрээний Акт 1999 (Их Британи) (Гуравдагч талын эрх) болон Иргэний хуулийн дагуу гэрээнд заасан аливаа эрхийг гэрээнд оролцоогүй этгээд эдлэхгүй.
- 23.2 Компанийн төлөөлөгч нь 21-р зүйл болон бусад өөрийн ашиг сонирхлыг тусгасан бүх зүйл заалтуудыг дагаж мөрдүүлэх эрхтэй.

24. Эрхээс татгалзах, нэмэлт өөрчлөлт

- 24.1 Гэрээнд заагдсан бүгд буюу зарим эрх үүргээсээ татгалзах тохиолдолд:
- (a) зөвхөн Компани бичгээр зөвшөөрөл өгч баталгаажуулсан үед хүчинтэй;
 - (b) зөвхөн онцгой нөхцөлд зөвшөөрөгдөнө;
 - (c) тодорхой хугацаа заагаагүй бол түр хугацаанд үргэлжлэх
 - (d) гэрээний бусад хугацаа нөхцөлөөс татгалзах үндэслэл болохгүй байх
- 24.2 Зөвхөн бичгээр гаргасан тохиолдолд энэхүү Гэрээний нэмэлт өөрчлөлтийг хүчин төгөлдөрт тооцно.

25. Нийт гэрээ

Гэрээний заалтуудын дагуу нэмэлт өөрчлөлт оруулсан гэрээ нь талуудын хооронд байгуулсан бүхий л тохиролцоог илэрхийлэх бөгөөд тухайн асуудлаар талууд урьд өмнө амаар болон бичгээр хийсэн бүх тохиролцоо, шалгаруулалтын мэдэгдэл, худалдан авалтын захиалга, заалтууд, ойлголцол болон бичиг баримт, үүнд гэрээтэй холбоотой аливаа тендерийн бичиг баримтыг хүчингүйд тооцно.

26. Заалт хүчингүй болгох

- 26.1 Гэрээний аль нэг зүйл заалт нь аль нэг улсын хууль тогтоомжоор хүчингүй, хэрэгжүүлэх боломжгүй нь тогтоогдвол нэмэлт өөрчлөлт оруулсанд тооцох ба тэрхүү нэмэлт заалтуудын хүрээнд талууд боломжит хэмжээнд өөрсдийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хэрэгжүүлнэ.
- 26.2 Тухайн улс орны хуулиар хугацаагүй зөвшөөрөл, үүрэг олгохыг хориглосон нөхцөлд

энэхүү гэрээнд заасан зөвшөөрөл болон үүргийг тухайн улсын хууль дүрэм, тогтоосон хугацааны боломжит дээд хэмжээгээр олгосон гэж үзнэ.

27. Санхүүжилтийн тохиролцоо

27.1 Санхүүжилт авахад дэмжлэг үзүүлэх

Гүйцэтгэгч тал нь Компанийн хүсэлтээр энэхүү төслийг санхүүжүүлэхэд шаардлагатай бичиг баримтаар хангах буюу бусад дэмжлэгийг үзүүлэх үүрэгтэй.

27.2 Шууд хэлэлцээр

Компанийн шаардсанаар гүйцэтгэгч тал, мөн санхүүжүүлэгчдийн шаардсанаар гүйцэтгэгчийн батлан даагч нь:

- (a) санхүүжүүлэгчдийн шаардсан хэлбэрээр шууд хэлэлцээрт оролцох; ба/эсвэл
- (b) санхүүжүүлэгчдээс хүссэн аливаа бусад бичиг баримтыг үйлдэх;

27.3 Санхүүжүүлэгчидтэй харилцах

- (a) Гүйцэтгэгч тал нь Компаниас хүсэлт гаргасан тохиолдолд санхүүжүүлэгчид, түүний төлөөлөгчидтэй хамтран ажиллаж, мэдээллээр хангана
- (b) Компани нь санхүүжүүлэгч, тэдгээрийн төлөөлөгчидтэй өрнүүлэх аливаа харилцааг зохицуулах буюу хариуцна.

БҮЛЭГ В. Худалдан Авалтын Ерөнхий Нөхцөл

28. Гүйцэтгэх ажлууд

28.1 Гүйцэтгэгч нь Ажил үүргүүддээ, мөн Ажил үүргүүдийн бүрдэл бүртээ (үүнд Бараа материал хамаарна) дараах баталгааг өгч байна:

- (a) Ажил үүргийг гүйцэтгэж буй зорилгод нийцсэн, өөрөөр бол Гэрээнд заасан шалгуур, гэрээний нөхцөл шаардлагыг хангасан.
- (b) холбогдох стандартыг хангасан;
- (c) Холбогдох хууль, үүнд Монгол Улсын Барилгын Тухай Хууль, Аж Ахуйн Үйл Ажиллагааны Тусгай Зөвшөөрлийн Тухай Хуульд заасан шаардлагыг хангах буюу буюу тэдгээр хуулийн дагуу тусгай зөвшөөрөл, ерөнхий зөвшөөрөл, эрхийг авах.
- (d) холбогдох хууль журмыг дагаж мөрдөх;
- (e) гэрээнд заагдсантай ижил төстэй ажил үүргийг гүйцэтгэдэг нэр хүнд бүхий, өрсөлдөгч байгууллагын баримталдаг ур чадвар, ажил гүйцэтгэлийн өндөр стандартад нийцүүлэх

28.2 Гүйцэтгэгч тал ажлаа цаг тухайд нь амжуулж, Ажил үүргийг Гүйцэтгэж дуусах хугацаанд нь дуусгах ёстой.

28.3 Гүйцэтгэгч нь Бараа материалыг эзэмшиж, худалдах чадвартай гэдгээ баталж байгаа болно.

28.4 Гүйцэтгэгч тал нь Компани, Компанийн ажилтны хэрэгцээнд зориулж худалдааны баталгааг ажил дуусахын өмнө авч Компанид хүлээлгэн өгнө.

29. Баталгаа

29.1 Гүйцэтгэгч нь Ажил үүрэгтээ болон ажил үүргийнхээ бүрэлдэхүүн хэсэг бүрд Гэрээг гүйцэтгэж дуусах өдөр болон Гэрээг цуцалсан өдрийн аль түрүүлж тохиолдсон өдрөөс хойш 12 сарын хугацаанд ердийн ажлын нөхцөлд ямар ч доголдол гарахгүй гэдэгт баталгаа өгч байгаа болно.

29.2 Гэрээний Хугацаа болон дээрх хугацааны турш ямар нэгэн доголдолтой ажил үүргээ засаж залруулах буюу солих (шаардлагатай бол) арга хэмжээг өөрийн зардлаар авч гүйцэтгэж, аль болох түргэн хугацаанд хэвийн ажиллагаатай нөхцөлд оруулах бөгөөд тухайн доголдлоос шууд болон шууд бусаар үүсэж, эсвэл доголдолтой ажил үүргийг засаж залруулснаас эсвэл сольсноос үүдэж гүйцэтгэх ажлын бусад зүйлд болон Компанийн өмчид учирсан аливаа хохирлын хариуцлагыг Гүйцэтгэгч тал хариуцна.

29.3 Гүйцэтгэгч тал Компаниас бичгээр мэдэгдэл хүлээж авснаас хойш зохих ёсны хугацаанд доголдлыг Компанийн сэтгэл ханамжид хүрэхүйцээр залруулж, ямарваа шууд буюу шууд бус (үүдэлтэй) хохирлыг арилгаж эс чадвал Компани дараах арга хэмжээг хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд тэдгээр нь доголдолтой холбоотойгоор Гүйцэтгэгчийн эсрэг Компанийн эдлэх бусад аливаа эрхийг хязгаарлахгүй.

- (a) Доголдолтой ажлыг Гүйцэтгэгчийн зардлаар Гүйцэтгэгч талд буцаан хүргүүлэх.
- (b) Доголдлыг засаж залруулж чадаагүй явдлыг 17-р зүйлд заасан зөрчил гэж хандах.
- (c) уг доголдлыг Гүйцэтгэгч эрсдэл, зардлыг хариуцан өөрөө засаж залруулна.

29.4 29.3(a) дэд заалтын дагуу Ажил үүргийн хэсгийг буцаасан бол тус буцаасан зүйлтэй

холбоотой нэхэмжлэл буюу бусад шаардлагын дагуу Гүйцэтгэгч нь Компанийн төлсөн аливаа мөнгөн дүнгээр Компанийг хохиролгүй болгоно.

29.5 Компанийг өөрөөр зөвшөөрөөгүй бол Гүйцэтгэгчийн доголдол буюу зөрчлийг засаж арилгах ажлыг Уурхай талбай дээр гүйцэтгэх ёстой.

30. Үзлэг, шалгалт

30.1 Компани нь гүйцэтгэх ажлын аль ч бүрдэл хэсэгт, эсвэл Уурхайн талбар дээр байгаа эсэхээс үл хамааран аль ч Бараа материалд үзлэг, шалгалтыг хэзээд хийх эрхтэй байна.

30.2 Энэхүү 30-р зүйлийн дагуу хийсэн аливаа үзлэг, шалгалт ажлыг гүйцэтгэхтэй холбоотой Гэрээгээр олгогдсон аливаа үүрэг хариуцлагаас нь Гүйцэтгэгч талыг чөлөөлөхгүй.

30.3 Энэхүү 30-р зүйлд заасан эрхээ Компани эдлэх нь гүйцэтгэх ажилтай холбоотойгоор Компанийн эдлэх бусад эрх, засаж залруулах ажилтай хамааралгүй байна.

31. Хүргэлт

31.1 Гэрээг гүйцэтгэхэд Гүйцэтгэгч тал Уурхайн талбар луу болон тэндээс Бараа материалыг тээвэрлэх шаардлагатай бол (Компани бичгээр өөрөөр мэдэгдээгүй бол) Компани тухайн Бараа материалын төлбөрийг хийсэн эсэхээс үл хамааран Гүйцэтгэгч тал дамжин өнгөрөх үеийн Бараа материалын хорогдол, гэмтлийн даатгалыг хариуцна. Тухайн даатгалд Компанийг даатгалын гэрээний дагуу даатгуулагч нэг талаар тэмдэглэсэн байна.

31.2 Гүйцэтгэгч нь Компанид уурхайн талбараас гадуур үйлдвэрлэсэн аливаа бараа материал, бүтээгдэхүүнийг тээвэрлэсэн огноо, уурхайн талбарт хүргэгдэх огноог Компанийн төлөөлөгчид тэр даруйд мэдэгдэнэ.

31.3 Гүйцэтгэгч тал нь Компанийн төлөөлөгчөөс зөвшөөрөл аваагүй тохиолдолд уурхайн талбар луу аливаа бараа материалыг авчрах, хүргэхийг хориглоно. Зөвшөөрлийг Компанийн төлөөлөгч тохиромжтой гэж үзсэн нөхцөл шаардлагаар олгоно.

31.4 Өөрөөр заагаагүй бол гүйцэтгэгч тал нь Компани эсвэл гүйцэтгэгчээр эсвэл тэдгээрийн захиалгаар уурхайн талбарт хүргэгдсэн бүх бараа материалын савлалт, тээвэрлэлт, буулгалтыг хариуцна. (Хавсралт Е-д заасан нөхцөл шаардлагыг хангасан байх)

31.5 Хэрэв гэрээнд бараа материалын тээвэрлэлтийг Компани хариуцна гэж заасан бол гүйцэтгэгч тал Компанийн төлөөлөгчид тухайн тээвэрлэгдэхэд бэлэн болсон бараа материалын дэлгэрэнгүй мэдээллийг өгч, тээвэрлэхэд шаардагдах хугацааг мэдэгдэнэ.

31.6 Гүйцэтгэгч тал нь Компани, Компанийн ажилтанд гаалийн мэдүүлэг бэлтгэхэд зориулан өгсөн аливаа мэдээлэл нь дутуу, буруу байснаас үүдэлтэй аливаа хариуцлагаас Компани, түүний ажилтныг чөлөөлөх үүрэгтэй.

32. Эзэмшил, эрсдэл

32.1 Гэрээгээр гүйцэтгэх Ажил эсвэл Ажлын аливаа хэсгийн өмчлөл, эзэмшил нь Компанид дараах зүйлсээс өмнө шилжинэ:

- (a) гүйцэтгэсэн ажил үйлчилгээнд зориулан төлбөр хийх (хэсэгчлэн төлөлт хийсэн тохиолдолд тухайн хэсэгчлэн төлөлт хийх үнийн дүнд багтаан);
- (b) Монгол улсын нутаг дэвсгэрийн гаднаас бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх үед;
- (c) Монгол улсын нутаг дэвсгэрээс бараа бүтээгдэхүүн нийлүүлж уурхайн талбарт нэвтрүүлэх үед

- (d) гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээний аливаа нэг хэсгийг Компанийн эзэмшилд буюу хариуцаж байсан өмч, ажил үйлчилгээтэй нэгтгэх.
- 32.2 32.1 дэд заалтыг үл харгалзан, эзэмшигчээс үл хамааран гүйцэтгэх ажлыг Компани хүлээн авах хүртэл тухайн ажлын эрсдэлийг Гүйцэтгэгч тал хариуцна.
- 32.3 Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээний дагуу Компанид хүргүүлсэн Бараа материалыг хадгалахаас татгалзах ба Гүйцэтгэгч нь холбогдох Туслан гүйцэтгэгч ч мөн Гүйцэтгэгчийн өмнө адил хадгалахаас татгалзсан баталгааг авах ёстой.
- 33. Гэрээг цуцалсан тохиолдолд гарах үр дагаврууд**
- 33.1 Гэрээнд оролцогч аль нэг тал 17-р зүйлийн дагуу гэрээг цуцлах мэдэгдэл өгсөн тохиолдолд Гүйцэтгэгч тал:
- (a) Компани, Компанийн төлөөлөгчөөс өгсөн чиглэлийн дагуу гэрээгээр хийж гүйцэтгэх ажил үйлчилгээ буюу ажил үйлчилгээний хэсгийг нэн даруй зогсоох;
- (b) Компани, Компанийн төлөөлөгчөөс өгсөн гэрээ цуцлах мэдэгдэлд тусгасан, эсвэл өөрөөр өгөгдсөн аливаа чиглэл зааврыг дагаж мөрдөх;
- (c) гэрээ цуцалснаас бий болох аливаа гарз хохирлыг бууруулах арга хэмжээг нэн даруй авах;
- (d) гэрээг цуцлах мэдэгдэл өгснөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Компанид Компанийн төлөөлөгчөөс шаардсан хэв маягтад нийцүүлэн гэрээ цуцлах өдөр хүртэл (үүнд тус өдөр багтана) гэрээний дагуу гүйцэтгэсэн ажил үйлчилгээ болон нийлүүлсэн Бараа материалын талаарх тайланг явуулах;
- (e) Компаниас гүйцэтгэгчид олгосон аливаа эд материалыг аль болох богино хугацаанд буцаан өгөх;
- (f) Гүйцэтгэгчийн буюу түүний өмнөөс хэн нэгний бэлтгэсэн Баримтжуулалтыг (бүрэн эсвэл бүрэн бус) Компанид хүлээлгэн өгөх;
- 33.2 Хэрэв Гэрээг 17.1 дэд заалт эсвэл 17.2 дэд заалтын дагуу цуцалсан бол:
- (a) Компанийн төлөөлөгч нь дараах зүйлсийн урьдчилан тооцоолсон болон бодит үнийг дүнг баталгаажуулна:
- (i) Гүйцэтгэх Ажлын үлдэгдлийг гүйцэтгэх болон дуусгахад гарсан зардал;
- (ii) Гүйцэтгэгч талд төлсөн бүх төлбөр;
- (iii) Үлдэгдэл Буцаалтын дүн;
- (iv) гүйцэтгэгч тал урьд өмнө гэрээг зөрчсөнтэй холбоотой (үүнд ажил хойшлох) түүнчлэн гэрээг цуцалсантай холбоотой гарах бүх үүргүүд болон нэмэлт зардлууд; эдгээрийг дараахаас хасна:
- (v) Ажил үйлчилгээ нь Гэрээний дагуу гүйцэтгэгдэж дууссан бол Гэрээний үнэ буюу хэрэв бүхэл дүн биш бол Гэрээний үнийг Компанийн төлөөлөгч тооцоолж гаргасан дүн; мөн
- (b) 33.2(a) дэд заалтад заасны дагуу гэрчилсэн үнийн дүн нь нэмэх дүнтэй гарвал тэрхүү дүнг Гүйцэтгэгчийн Компанид төлөх өр гэж үзэх бөгөөд Компаниас гүйцэтгэгч талд төлөгдөх төлбөрөөс суутгана.
- 33.3 Хэрэв гэрээг 17.3 дэд заалт эсвэл 17.4 дэд заалтын дагуу цуцалсан бол гүйцэтгэгч тал

Компаниас нөхөн төлбөр авах эрх үүснэ (урьд өмнө төлөгдсөнөөс бага үнийн дүнтэй, мөн Компанийн суутгах, хасах эрхтэй төлбөрүүдийг харгалзан):

- (a) Гэрээг цуцлах өдөр хүртэл гэрээний дагуу гүйцэтгэсэн бүх ажлуудын үнийн дүн
- (b) гэрээний дагуу ажил гүйцэтгэхэд зориулан захиалж гүйцэтгэгч талд хүргэгдсэн аливаа бараа материалын зардал, мөн Гүйцэтгэгчийн зардлаар нийлүүлсэн бараа материал нь Компанийн өмч болсон тохиолдолд;
- (c) гүйцэтгэгч тал өөрийн өмч хөрөнгө, ажилтнуудыг уурхайн талбараас нүүлгэхэд гарсан зардал (үүнд 17.3, 17.4 дэд заалтын дагуу Гүйцэтгэгчийн ажилтныг гэрээний ажил үүргээс чөлөөлөхөд гүйцэтгэгч талаас гарсан зардлыг тооцохгүй);
- (d) гэрээ цуцлах үед Компани, Компанийн төлөөлөгчөөс өгсөн заавар чиглэлийг хэрэгжүүлэхэд гарсан зардал
- (e) гүйцэтгэгч тал туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу туслан гүйцэтгэгчид төлсөн гэрээ цуцлах төлбөр;

Дээрх бүх зардал нь үнэн бодитой байх мөн гүйцэтгэгч тал дээрх зардлыг бууруулахын тулд шаардлагатай бүх арга хэмжээг авсан тохиолдолд нөхөн төлбөрийг олгоно.

- 33.4 Гүйцэтгэгч талд гэрээг цуцалснаас үүдсэн аливаа ашиг орлогын алдагдлыг нөхөн төлүүлэх эрх үүсэхгүй байна.

БҮЛЭГ С. Уурхайн Талбартай Холбогдох Заалтууд

34. Уурхайн талбар

- 34.1 Гүйцэтгэгч тал нь Компаниас мэдэгдсэн уурхайн талбарын бүх дүрэм журам, үүнд Хавсралт А-д заасан уурхайн талбарт тавигдах тусгай нөхцөл шаардлагуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.
- 34.2 Гэрээнд тусгайлан заагаагүй тохиолдолд Гүйцэтгэгч тал нь өөрийн ажилтныг уурхайн талбараас болон уурхайн талбар луу тээвэрлэх зардлыг хариуцна.
- 34.3 3.3(с) ба 34.1 дэд заалтуудыг зөрчсөн тохиолдолд Компани нь:
- (a) гүйцэтгэгч тал, Гүйцэтгэгчийн ажилтан болон бусад этгээдийг уурхайн талбараас нэн даруй явахыг шаардах эрхтэй;
 - (b) гүйцэтгэгч тал, түүний ажилтныг уурхайн талбараас аливаа материал буюу бодисыг зайлуулахыг шаардах эрхтэй, ба

Гүйцэтгэгч тал нь тухайн шаардлагыг нэн даруй дагаж биелүүлэх ба бүх Ажилтны аюулгүй байдлыг хангах боломжит бүхий л арга хэмжээг авна.

- 34.4 Гүйцэтгэгч тал нь бүх зааварчилгаа, мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгааг Англи, Монгол хэл дээр, түүнчлэн аливаа холбогдох гадаад хэл дээр боловсруулах бөгөөд (шаардлагатай тохиолдолд), ингэхдээ Монгол Хэлний Тухай хуулийг мөрдлөг болгоно.

35. Уурхайн талбарт нэвтрэх

Компани нь гүйцэтгэгч талыг бичгээр зөвшөөрсний дагуу эсвэл Захиалгын маягт дээр заасны дагуу уурхайн талбарт нэвтрүүлнэ.

36. Уурхайн талбарын бусад заалт

- 36.1 Гүйцэтгэгч тал нь уурхайн талбарт ажиллахад тусгай эрх олгогдохгүй бөгөөд зөвхөн Компанийн төлөөлөгчөөс гэрээний ажил үүргийг биелүүлэхэд шаардлагатай гэж үзсэн хэсгүүдэд хуваарилагдаж ажиллах үүрэгтэй.
- 36.2 Гүйцэтгэгч тал нь Компани, түүний ажилтан болон бусад гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч (Компанийн ажилтан мөн эсэхээс үл хамааран) талуудын ажилд саад учруулахгүйгээр хамтран ажиллах ба тэдгээр талуудад холбогдох ажил үүргээ зөв зохистой гүйцэтгэхэд нь шаардлагатай мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.
- 36.3 Гүйцэтгэгч талд бусад гүйцэтгэгчид, ханган нийлүүлэгчдийн зүгээс ажилд саад учруулсны улмаас гомдол нэхэмжлэл гаргах эрх үүсэхгүй (Компанид ажилладаг буюу хамтран ажиллагч эсэхээс үл хамааран).

37. Эрүүл Мэнд, Аюулгүй Ажиллагаа, Байгаль Орчин, Орон Нутаг

- 37.1 Гүйцэтгэгч тал нь өөрийн ажилтны эрүүл мэнд аюулгүй ажиллагааг хариуцах үүрэгтэй.
- 37.2 Гүйцэтгэгч тал нь өөрсдийн ЭМААБООН-ын санал болгож буй төлөвлөгөөг Компанийн төлөөлөгчид явуулж хянуулах бөгөөд Компанийн төлөөлөгчөөс төлөвлөгөөг хүлээлгэн өгөх хүсэлт гаргаснаас ажлын 10 өдөрт багтаан хүлээлгэн өгнө. Энэ нь Ажил үйлчилгээ эхлэхээс өмнө байх ёстой. Гүйцэтгэгч нь ЭМААБООН-ын төлөвлөгөөг Компанийн дүрэм журам, Монгол Улсын Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуйн Тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Хөдөлмөр, Эрүүл Мэндийн Яамнаас боловсруулсан загвар хөтөлбөрт нийцүүлэн боловсруулна.

- 37.3 Компанийн төлөөлөгч нь тэрхүү санал болгосон ЭМААБООН-ын төлөвлөгөөг хянаж баталсныг мэдэгдэх эсвэл шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтийг хүргүүлнэ.
- 37.4 Гүйцэтгэгч тал нь Компанийн төлөөлөгчөөс нэмэлт өөрчлөлт хийх шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан Компанийн төлөөлөгчийн дүгнэлтийн дагуу ЭМААБООН-ын төлөвлөгөөг шинэчилж, хүлээлгэн өгнө. 37.3 болон энэхүү дэд заалтад заасан журам нь Компани ЭМААБООН-ын төлөвлөгөөг батлах хүртэл үргэлжлэн хэрэгжинэ.
- 37.5 Компанийн төлөөлөгч нь ЭМААБООН-ын төлөвлөгөө батлагдах хүртэл гэрээний ажлыг хойшлуулах, уурхайн талбар луу нэвтрэхээс татгалзах эрхтэй.
- 37.6 Компанийн төлөөлөгч нь аль ч үед гүйцэтгэгч талд батлагдсан ЭМААБООН-ын төлөвлөгөөг өөрчлөх шаардлага тавих эрхтэй бөгөөд энэ тохиолдолд 37.2, 37.3, 37.4 дэд заалтуудыг мөрдлөг болгоно.
- 37.7 Гүйцэтгэгч тал нь ЭМААБООН-тай холбоотой холбогдох хууль журам, батлагдсан, ЭМААБООН-ын төлөвлөгөөний сүүлийн хувилбарыг бүх ажилтнуудад мөрдлөг болгож ажиллуулах үүрэгтэй.
- 37.8 Гүйцэтгэгч, түүний ажилтны хайхрамжгүй үйлдэл гаргах, ажил орхигдуулах, ажил явуулах чадамжгүй болох зэргээс үүдэн Компанийг ЭМААБООН-ын холбогдох хууль журмын дагуу хүлээсэн үүргээ зөрчих нөхцөлийг үүсгэхгүй байх үүрэгтэй.
- 37.9 Гүйцэтгэгч тал нь гүйцэтгэгч түүний ажилтан холбогдох ЭМААБООН-ын хууль, болон энэхүү 37-р зүйлийг зөрчсөнөөс үүдэн гарах аливаа зардал, эвдрэл, гарз, хохирлоос Компани түүний ажилтныг чөлөөлнө (үүнд өмгөөллийн зардал багтана).
- 37.10 Гүйцэтгэгч тал нь өөрийн зардлаар Гүйцэтгэгчийн бүх ажилтныг Монгол улсын Эрүүл Мэнд, Хөдөлмөрийн Яамнаас олгосон дүрэм ЭМААБООН-ын журам тогтоолын дагуу ЭМААБООН-ын сургалтад хамруулах үүрэгтэй.
- 37.11 Гүйцэтгэгч нь Монгол Улсын Хөдөлмөрийн Аюулгүй Байдал ба Эрүүл Ахуйн тухай хуулийн дагуу ЭМААБООН-тай холбоотой үйл ажиллагаа, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан боломжит доод хэмжээний зардлыг зарцуулах үүрэгтэй.
- 37.12 Гүйцэтгэгч нь Монгол Улсын Галын Аюулгүй Байдлын Тухай хуульд заасан нөхцөл шаардлага, үүрэг хариуцлагыг дагаж мөрдөх үүрэгтэй.

БҮЛЭГ D. Бусад Заалтууд**38. Гэрээ байгуулагч хуулийн этгээд**

- 38.1 Талууд нь Компани өөрийн эрх, ашиг сонирхлын дагуу мөн эцсийн хэрэглэгчийн эрх ашгийг итгэмжлэн төлөөлөх эрхийнхээ дагуу энэхүү гэрээнд оролцсон болохыг мөн энэхүү ашиг сонирхол болон итгэмжлэл нь аль ч хэлбэрээр эцсийн хэрэглэгчид гэрээний дагуу болон бусад хэлбэрээр шууд олгогдсон аливаа эрхээр хязгаарлагдахгүй болохыг хүлээн зөвшөөрч байна.
- 38.2 Энэхүү гэрээний дагуу Компанид олгосон аливаа эд хөрөнгийг өмчлөх эрх болон аливаа бусад эрхүүд нь Компани эцсийн хэрэглэгчийг өөрийн эрх, чадамжийн хүрээнд итгэмжлэн төлөөлөх тохиолдолд мөн адил хүчин төгөлдөр байх бөгөөд, тэдгээр эрх нь Компани болон эцсийн хэрэглэгчийн энэхүү гэрээнд оролцох хувь хэмжээгээр хязгаарлагдана.

39. Хүчин төгөлдөр хэвээр үлдэх

- 39.1 Гэрээг цуцалсан тохиолдолд эсвэл цуцалсны дараа хүчин төгөлдөр хэвээр байна гэж илт эсвэл далд утгаар заасан энэхүү Гэрээний аливаа заалт нь хүчин төгөлдөр хэвээр байна.